



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ганзоригийн ТЭМҮҮЛЭН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-25-28, Факс: 32-70-16
E-mail: temuulen@parliament.mn
<http://www.parliament.mn>

2024.03.25 № УИХ-03/2203

танай _____-ны № _____-т

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад нэмэлт оруулах тухай тогтоолын төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлж өгөхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Г.ТЭМҮҮЛЭН

С.БЯМБАЦОГТ

Ж.БАТЖАРГАЛ

Б.БАТТӨМӨР

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Н.ГАНИБАЛ

Г.ДАМДИННЯМ

О.ЦОГТГЭРЭЛ

Т.ЭНХТҮВШИН

000123



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ганзоригийн ТЭМҮҮЛЭН

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон.
Утас: 26-25-28, Факс: 32-70-16
E-mail: temuulen@parliament.mn
http://www.parliament.mn

2023.04.04 № УИХ-03/2863

танай _____-ны № _____-т

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай


Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад нэмэлт оруулах тухай тогтоолын төслийг санаачлан боловсрууллаа. Тогтоолын төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон холбогдох материалыг хавсаргав.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйл, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хавсралт 20 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Г.ТЭМҮҮЛЭН

С.БЯМБАЦОГТ

Ж.БАТЖАРГАЛ

Б.БАТТӨМӨР

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Н.ГАНИБАЛ

Г.ДАМДИННЯМ

О.ЦОГТГЭРЭЛ

Т.ЭНХТҮВШИН

000150



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 ^{ад} он ⁰⁴ дугаар
сарын ⁰¹ -ны өдөр

Дугаар ^{ХЭГ} / ¹⁵³⁷

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.БЯМБАЦОГТ
ТАНАА

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000225009436

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны 35 дугаар тэмдэглэлд:

“Ү.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын санаачлан боловсруулсан “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын санаачлан боловсруулсан “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд зарчмын хувьд дэмжиж, дараахь саналыг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:


1. “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” Улсын Их Хурлын 1998 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалт”-ын 3 дахь хэсгээс “, бүтээгдэхүүн” гэснийг Улсын Их Хурлын 2006 оны 92 дугаар тогтоолоор хассан байх тул тогтоолын төслийн 1 дэх заалтын “, бүтээгдэхүүн” гэснийг хасах;

2. Тогтоолын төслийн гарчгийг “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” гэж, мөн тогтоолын төслийн үндэслэх хэсгийн “Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг” гэснийг “Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5.1 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 8.1 дэх хэсгийг тус тус” гэж тус тус өөрчлөх нь зүйтэй байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН**



Г.ТЭМҮҮЛЭН

С.БЯМБАЦОГТ

“ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад нэмэлт оруулах үндэслэл, шаардлагыг дараах байдлаар тодорхойлж байна.

1.1 Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д зааснаар эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д 1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна хэмээн хуульчилсан. Монгол Улсын Их Хурлаас иргэний энэхүү үндсэн эрх, эрх чөлөөг байнга баталгаажуулан хамгаалахыг эрмэлзсээр ирсэн.

Монгол Улсын Их Хурал 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр “Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолыг баталсан бөгөөд тогтоолын 4 дэх хэсэгт “..... зохист хэмжээнээс их хорт утаа ялгаруулж байгаа авто тээврийн хэрэгсэл, зориулалтын бус түлш хэрэглэн химийн хорт бодис ялгаруулж агаарын чанар, нийгмийн эрүүл мэндэд хохирол учруулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг чангатгаж, таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;” талаар тусгасан. Гэтэл сүүлийн жилүүдэд хууль тогтоогчийн дээрх бодлого, Үндсэн хуулиар тунхагласан хүний үндсэн эрх, эрх чөлөөг хөндсөн үйлдэл гарах боллоо. Тухайлбал: автомашинаас ялгарах хорт утааг шүүх зориулалттай нүүрсэн янданг хулгайн аргаар болон сайн дураар худалдан борлуулах, улсын хилээр гаргах үйлдэл ихээр гарах болсон нь Нийслэлийн агаарын бохирдлыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх болсныг холбогдох судалгааны байгууллагууд танилцуулах болжээ. Өөрөөр хэлбэл автомашины нүүрсэн яндагийн талаар зохицуулсан хууль, эрх зүйн акт байхгүй байна. Иймд Монгол Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” 05 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт оруулж, автомашины нүүрсэн янданг улсын хилээр гаргахыг хориглох барааны жагсаалтад оруулах талаар зохицуулах.

1.2. Практик шаардлага

Автомашины хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагч бодисууд нь хүний эрүүл мэндэд хор хөнөөл учруулж, уур амьсгалын өөрчлөлтийг үүсгэдэг хүлэмжийн хийг нэмэгдүүлдэг. Бензин, дизель тулшийг шатаахад азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл, нүүрс устөрөгч, бензол, формальдегид зэрэг хортой 200 гаруй бодисууд (тулшний чанар болон бусад холбогдох хүчин зүйлсийн нөлөөллөөр 300 хүртэлх төрлийн хорт бодис ялгардаг) бий болохоос гадна хамгийн түгээмэл хүлэмжийн хий болох нүүрстөрөгчийн давхар ислийг ихээр үүсгэдэг. Америкийн нэгдсэн улсын Environmental Protection Agency байгууллагын хийсэн судалгаагаар хот суурин орчмын агаар мандал дахь бүх нүүрстөрөгчийн дутуу ислийн (CO) 95% нь автомашинаас ялгарч, жил бүр 1.7 тэрбум тонн хүлэмжийн хий үүсгэдэг болохыг тогтоосон байна. Автомашинаас ялгарах хорт бодисын хэмжээ ба түүнээс үүдэх агаарын бохирдлыг бууруулахын тулд олон улсад TA 9/2009, FR 9/2011, UN Reg 83, 70/220EC, 715/2007EC, 2017/1151, 692/2008EC, EURO-5 зохицуулалтууд болон холбогдох бусад бүх нийтээр дагаж мөрдөх баримт бичгээр автомашинаас ялгарах утаан дахь хорт бодисын хэмжээг бууруулах, саармагжуулах төхөөрөмжид тавигдах техникийн шаардлага болон утаанд агуулагдах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоож, дагаж мөрдөх үүргийг үйлдвэрлэгчдэд хүлээлгэсэн байдаг. Тухайлбал Евро 5 стандарт 2009 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж, тус стандартаар хөдөлгүүрээс ялгарах утаан дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоож, автомашин үйлдвэрлэгчид хорт бодисын хэмжээг зөвшөөрөгдөх дээд хэмжээнд хүртэл саармагжуулах боломжтой систем, төхөөрөмжөөр автомашиныг бүрэн тоноглож эрх бүхий олон улсын хяналтын байгууллагаар сорилт, туршилт хийлгэн баталгаажуулж зах зээлд нийлүүлдэг. Энэ нь автомашины нүүрсэн яндан буюу катализатор юм.

Олон улсын зах зээлд цагаан алт, родий, палладий зэрэг үнэт металлуудын эрэлт ихсэж, үнэ нэмэгдэж байгаатай холбоотойгоор автомашины нүүрсэн яндан /катализатор/-ыг дахин боловсруулж үнэт метал гарган авч худалдаалах хандлага ихээхэн гарч байна. Мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас агаарын бохирдол, утаатай тэмцэх зорилгоор утаа их хаядаг автомашиныг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх хууль гарч, сайн шүүлтүүртэй яндангийн эрэлт хэрэгцээ нэмэгдсэн нь эдэлгээ удаантай, шүүлтүүр сайтай элемент агуулдаг Япон Улсад үйлдвэрлэгдсэн хабрид автомашинуудын нүүрсэн яндангийн эд ангийг хулгайлах гэмт хэргийн гаралт нэмэгдсэн бөгөөд иргэд сайн дураараа өөрийн болон бусдын автомашины нүүрсэн янданг худалдан борлуулах, үнэ нэмж дамлан зарах үйлдэл эрх ихэссэн.

Мэргэжлийн байгууллагын ирүүлсэн мэдээллээс үзэхэд 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд 1.259.868 автомашин хөдөлгөөнд оролцож байгаагаас нийслэлд 676.974, орон нутагт 582.894 автомашин хөдөлгөөнд оролцож байна. Нийслэл хотын хэмжээнд тоёота приус маркийн 133.235 автомашин хөдөлгөөнд оролцож байна. Цагдаагийн байгууллагад сүүлийн 4 жилийн байдлаар автомашины зөөлөн яндан алдагдсан дуудлага, мэдээлэл 892 бүртгэгдсэн бөгөөд 2021 онд 129, 2022 оны нэгдүгээр улирлын байдлаар 19 гэмт хэрэг байна.

Монгол Улсад автомашины нүүрсэн янданг авдаг сүлжээ үүссэн бөгөөд Бүгд Найрамдах Хятад Ард Улсруу хил нэвтрүүлэн худалдан борлуулдаг. Гаалийн Ерөнхий Газраас ирүүлсэн мэдээллээс үзэхэд 2020-2021 оны хооронд Улсын хилээр катализаторын хаягдал нэрээр 27 тонн 585 кг автомашины нүүрсэн янданг хилээр гаргасан байна. Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны

жагсаалтад багтдаггүй тул хулгайн замаар болон бусад байдлаар цугларсан нүүрсэн янданг энгийн горимоор гаалийн бүрдүүлэлт хийж улсын хилээр нэвтрүүлдэг байна.

Автомашинь хөдөлгүүрээс ялгарах утаанд агуулагддаг онц аюултай нүүрсстөрөгчийн дутуу исэл (СО), нүүрс устөрөгч (НС), азотын исэл (NOx), хортой бохирдуулагч, утаа үүсгэгч бодисууд, хүхрийн исэл, тоосонцор, хар тугалганы нэгдлүүд, альдегид, бензапирен болон бусад 200 гаруй химийн хорт бодисууд катализаторгүй тохиолдолд шууд агаар мандалд цацагдаж ноцтой аюулд хүргэдэг учраас катализаторыг салгаж авах, зарах, хулгайлах зөрчил нь хүн болон хүрээлэн буй орчны эсрэг хийж буй онц аюултай үйлдэл гэж олон улсад үздэг.

Дээрх үндэслэлээр Монгол Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” 05 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт оруулж, автомашины нүүрсэн янданг улсын хилээр гаргахыг хориглох барааны жагсаалтад оруулах замаар эрэлтийг хязгаарлаж, гарч буй гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлүүд болон агаар орчны бохирдол үүсгэгч томоохон эх үүсвэр болсон автомашинаас ялгарч буй утааг бууруулах боломжийг бүрдүүлэх юм.

Хоёр. Тогтоолын зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөл 2 зүйлтэй, Монгол Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3 дахь хэсэгт нэмэлт оруулж, автомашины нүүрсэн яндан, нүүрсэн яндангийн хаягдлыг улсын хилээр гаргахыг хориглохоор тогтоолын төсөлд тусгасан болно.

Гурав. Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар гарах эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй бөгөөд автомашины нүүрсэн янданг хулгайлах гэмт хэрэг болон сайн дураар худалдан борлуулах, дамлан зарах, улсын хилээр нэвтрүүлэх үйлдэл таслан зогсоогдох бөгөөд агаар орчны бохирдол, ялангуяа Улаанбаатар хотын хэмжээнд нүүрсэн яндангүй автомашинаас ялгарч буй утаа багасах, агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлнө. Түүнчлэн автомашины нүүрсэн янданг хууль бусаар улсын хил нэвтрүүлэгч иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйлд зааснаар Эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой болно.

Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуультай нийцсэн байх бөгөөд бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй.

“ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, С.Бямбацогт нарын “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсрууллаа.

Нэг. Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д зааснаар эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д 1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна хэмээн хуульчилсан. Монгол Улсын Их Хурлаас иргэний энэхүү үндсэн эрх, эрх чөлөөг байнга баталгаажуулан хамгаалахыг эрмэлзсээр ирсэн.

Монгол Улсын Их Хурал 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр “Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолыг баталсан бөгөөд тогтоолын 4 дэх хэсэгт “..... зохист хэмжээнээс их хорт утаа ялгаруулж байгаа авто тээврийн хэрэгсэл, зориулалтын бус түлш хэрэглэн химийн хорт бодис ялгаруулж агаарын чанар, нийгмийн эрүүл мэндэд хохирол учруулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг чангатгаж, таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;” талаар тусгасан. Гэтэл сүүлийн жилүүдэд хууль тогтоогчийн дээрх бодлого, Үндсэн хуулиар тунхагласан хүний үндсэн эрх, эрх чөлөөг хөндсөн үйлдэл гарах боллоо. Тухайлбал: автомашинаас ялгарах хорт утааг шүүх зориулалттай нүүрсэн янданг хулгайн аргаар болон сайн дураар худалдан борлуулах, улсын хилээр гаргах үйлдэл ихээр гарах болсон нь Нийслэлийн агаарын бохирдлыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх болсныг холбогдох судалгааны байгууллагууд танилцуулах болжээ. Өөрөөр хэлбэл автомашины нүүрсэн яндагийн талаар зохицуулсан хууль, эрх зүйн акт байхгүй байна. Иймд Монгол Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” 05 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт оруулж, автомашины нүүрсэн янданг улсын хилээр гаргахыг хориглох барааны жагсаалтад оруулах талаар зохицуулах.

Хоёр. Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах бодит нөхцөл, судалгаа

Автомашины хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагч бодисууд нь хүний эрүүл мэндэд хор хөнөөл учруулж, уур амьсгалын өөрчлөлтийг үүсгэдэг хүлэмжийн хийг нэмэгдүүлдэг. Бензин, дизель тулшийг шатаахад азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл, нүүрс устөрөгч, бензол, формальдегид зэрэг хортой 200 гаруй бодисууд (тулшний чанар болон бусад холбогдох хүчин зүйлсийн нөлөөллөөр 300 хүртэлх төрлийн хорт бодис ялгардаг) бий болохоос гадна хамгийн түгээмэл хүлэмжийн хий болох нүүрстөрөгчийн давхар ислийг ихээр үүсгэдэг. Америкийн нэгдсэн улсын Environmental Protection Agency байгууллагын хийсэн судалгаагаар хот суурин орчмын агаар мандал дахь бүх нүүрстөрөгчийн дутуу ислийн (CO) 95% нь автомашинаас ялгарч, жил бүр 1.7 тэрбум тонн хүлэмжийн хий үүсгэдэг болохыг тогтоосон байна. Автомашинаас ялгарах хорт бодисын хэмжээ ба түүнээс үүдэх

агаарын бохирдлыг бууруулахын тулд олон улсад TA 9/2009, FR 9/2011, UN Reg 83, 70/220EC, 715/2007EC, 2017/1151, 692/2008EC, EURO-5 зохицуулалтууд болон холбогдох бусад бүх нийтээр дагаж мөрдөх баримт бичгээр автомашинаас ялгарах утаан дахь хорт бодисын хэмжээг бууруулах, саармагжуулах төхөөрөмжид тавигдах техникийн шаардлага болон утаанд агуулагдах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоож, дагаж мөрдөх үүргийг үйлдвэрлэгчдэд хүлээлгэсэн байдаг. Тухайлбал Евро 5 стандарт 2009 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж, тус стандартаар хөдөлгүүрээс ялгарах утаан дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоож, автомашин үйлдвэрлэгчид хорт бодисын хэмжээг зөвшөөрөгдөх дээд хэмжээнд хүртэл саармагжуулах боломжтой систем, төхөөрөмжөөр автомашиныг бүрэн тоноглож эрх бүхий олон улсын хяналтын байгууллагаар сорилт, туршилт хийлгэн баталгаажуулж зах зээлд нийлүүлдэг. Энэ нь автомашины нүүрсэн яндан буюу катализатор юм.

Олон улсын зах зээлд цагаан алт, родий, палладий зэрэг үнэт металлуудын эрэлт ихсэж, үнэ нэмэгдэж байгаатай холбоотойгоор автомашины нүүрсэн яндан /катализатор/-ыг дахин боловсруулж үнэт метал гарган авч худалдаалах хандлага ихээхэн гарч байна. Мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас агаарын бохирдол, утаатай тэмцэх зорилгоор утаа их хаядаг автомашиныг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх хууль гарч, сайн шүүлтүүртэй яндангийн эрэлт хэрэгцээ нэмэгдсэн нь эдэлгээ удаантай, шүүлтүүр сайтай элемент агуулдаг Япон Улсад үйлдвэрлэгдсэн хабрид автомашинуудын нүүрсэн яндангийн эд ангийг хулгайлах гэмт хэргийн гаралт нэмэгдсэн бөгөөд иргэд сайн дураараа өөрийн болон бусдын автомашины нүүрсэн янданг худалдан борлуулах, үнэ нэмж дамлан зарах үйлдэл эрх ихэссэн.

Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн мэдээллээс үзэхэд 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд 1.259.868 автомашин хөдөлгөөнд оролцож байгаагаас нийслэлд 676.974, орон нутагт 582.894 автомашин хөдөлгөөнд оролцож байна. Нийслэл хотын хэмжээнд тоёота приус маркийн 133.235 автомашин хөдөлгөөнд оролцож байна. Цагдаагийн байгууллагад сүүлийн 4 жилийн байдлаар автомашины зөөлөн яндан алдагдсан дуудлага, мэдээлэл 892 бүртгэгдсэн бөгөөд 2021 онд 129, 2022 оны нэгдүгээр улирлын байдлаар 19 гэмт хэрэг байна.

Монгол Улсад автомашины нүүрсэн янданг авдаг сүлжээ үүссэн бөгөөд Бүгд Найрамдах Хятад Ард Улсруу хил нэвтрүүлэн худалдан борлуулдаг. Гаалийн Ерөнхий Газраас ирүүлсэн мэдээллээс үзэхэд 2020-2021 оны хооронд Улсын хилээр катализаторын хаягдал нэрээр 27 тонн 585 кг автомашины нүүрсэн янданг хилээр гаргасан байна. Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны жагсаалтад багтдаггүй тул хулгайн замаар болон бусад байдлаар цугларсан нүүрсэн янданг энгийн горимоор гаалийн бүрдүүлэлт хийж улсын хилээр нэвтрүүлдэг байна.

Автомашины хөдөлгүүрээс ялгарах утаанд агуулагддаг онц аюултай нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), нүүрс устөрөгч (HC), азотын исэл (NOx), хортой бохирдуулагч, утаа үүсгэгч бодисууд, хүхрийн исэл, тоосонцор, хар тугалганы нэгдлүүд, альдегид, бензапирен болон бусад 200 гаруй химийн хорт бодисууд катализаторгүй тохиолдолд шууд агаар мандалд цацагдаж ноцтой аюулд хүргэдэг учраас катализаторыг салгаж авах, зарах, хулгайлах зөрчил нь хүн болон хүрээлэн буй орчны эсрэг хийж буй онц аюултай үйлдэл гэж олон улсад үздэг.

Дээрх үндэслэлээр Монгол Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” 05 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт оруулж, автомашины нүүрсэн яндан болон нүүрсэн яндангийн хаягдлыг улсын хилээр гаргахыг хориглох барааны жагсаалтад оруулах замаар эрэлтийг хязгаарлаж, гарч буй гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлүүд болон агаар орчны бохирдол үүсгэгч томоохон эх үүсвэр болсон автомашинаас ялгарч буй утааг бууруулах боломжийг бүрдүүлэх юм.

Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй бөгөөд автомашины нүүрсэн янданг хулгайлах гэмт хэрэг болон сайн дураар худалдан борлуулах, дамлан зарах үйлдэл болон улсын хилээр гаргах үйлдэл таслан зогсоогдох бөгөөд агаар орчны бохирдол, ялангуяа Улаанбаатар хотын хэмжээнд нүүрсэн яндангүй автомашинаас ялгарч буй утаа багасах, агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлнө. Түүнчлэн автомашины нүүрсэн янданг хууль бусаар улсын хил нэвтрүүлэгч иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйлд зааснаар Эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой болно. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуультай нийцсэн байх бөгөөд бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй.

---oOo---

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5.1 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 8.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3 дахь хэсгийн "зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа хар болон өнгөт төмөрлөгөөр хийсэн сэлбэг" гэсний дараа "автомашины нүүрсэн яндан, нүүрсэн яндангийн хаягдал" гэж нэмсүгэй.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, С.Бямбацогт нарын санаачлан боловсруулсан “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу судалсан болно. Энэхүү тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон олон улсын гэрээнд харшлаагүй нийцэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д зааснаар эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д 1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна хэмээн хуульчилсан. Монгол Улсын Их Хурлаас иргэний энэхүү үндсэн эрх, эрх чөлөөг байнга баталгаажуулан хамгаалахыг эрмэлзсээр ирсэн.

Монгол Улсын Их Хурал 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр “Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолыг баталсан бөгөөд тогтоолын 4 дэх хэсэгт “..... зохист хэмжээнээс их хорт утаа ялгаруулж байгаа авто тээврийн хэрэгсэл, зориулалтын бус түлш хэрэглэн химийн хорт бодис ялгаруулж агаарын чанар, нийгмийн эрүүл мэндэд хохирол учруулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг чангатгаж, таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;” талаар тусгасан. Гэтэл сүүлийн жилүүдэд хууль тогтоогчийн дээрх бодлого, Үндсэн хуулиар тунхагласан хүний үндсэн эрх, эрх чөлөөг хөндсөн үйлдэл гарах боллоо. Тухайлбал: автомашинаас ялгарах хорт утааг шүүх зориулалттай нүүрсэн янданг хулгайн аргаар болон сайн дураар худалдан борлуулах, улсын хилээр гаргах үйлдэл ихээр гарах болсон нь Нийслэлийн агаарын бохирдлыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх болсныг холбогдох судалгааны байгууллагууд танилцуулах болжээ. Өөрөөр хэлбэл автомашины нүүрсэн яндагийн талаар зохицуулсан хууль, эрх зүйн акт байхгүй байна. Иймд Монгол Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” 05 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт оруулж, автомашины нүүрсэн янданг улсын хилээр гаргахыг хориглох барааны жагсаалтад оруулах талаар зохицуулах.

Тогтоолын төслийг боловсруулах зорилго нь Монгол Улсын иргэний Үндсэн хуульд заасан эрхийг бүрэн эдлүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх зэрэгт оршино.

ХОЁР.АСУУДЛЫГ ҮҮСГЭЖ БУЙ УЧИР ШАЛТГААН

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д зааснаар эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д 1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн

эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна. гэж тус тус заасан нь төр иргэдийнхээ өмнө эрүүл, аюулгүй орчинд амьдруулах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас урьдчилан сэргийлэх, эрх нь аливаа хэлбэрээр зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг хуульчилсан.

Автомашин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагч бодисууд нь хүний эрүүл мэндэд хор хөнөөл учруулж, уур амьсгалын өөрчлөлтийг үүсгэдэг хүлэмжийн хийг нэмэгдүүлдэг. Олон улсын зах зээлд цагаан алт, родий, палладий зэрэг үнэт металлуудын эрэлт ихсэж, үнэ нэмэгдэж байгаатай холбоотойгоор автомашины нүүрсэн янданг дахин боловсруулж үнэт метал гарган авч худалдаалах хандлага ихээхэн гарч байна. Монгол Улсад автомашинуудын нүүрсэн яндангийн эд ангийг хулгайлах гэмт хэргийн гаралт нэмэгдсэн бөгөөд иргэд сайн дураараа өөрийн болон бусдын автомашины нүүрсэн янданг худалдан борлуулах, үнэ нэмж дамлан зарах үйлдэл эрх ихэссэн.

Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн мэдээллээс үзэхэд 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд 1.259.868 автомашин хөдөлгөөнд оролцож байгаагаас нийслэлд 676.974, орон нутагт 582.894 автомашин хөдөлгөөнд оролцож байна. Нийслэл хотын хэмжээнд тоёота приус маркийн 133.235 автомашин хөдөлгөөнд оролцож байна. Улсын хэмжээнд, ялангуяа Улаанбаатар хотын хэмжээнд нүүрсэн яндангүй автомашин замын хөдөлгөөнд оролцсоноор агаарыг ихээр бохирдуулж, агаарын чанарыг маш сөргөөр нөлөөлж байгаа нь судалгааны байгууллагын дүгнэлтээр гарч байна. Цагдаагийн байгууллагад сүүлийн жилүүдэд автомашины нүүрсэн яндан хулгайлах гэмт хэрэг болон сайн дураараа, үнэ дамлан худалдан борлуулах үйлдэл нэмэгдэж байгаа бөгөөд Улсын хилээр гаргаж зардаг бүлэглэл байгаа нь иргэдийн өмч хөрөнгөд халдах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхэд халдаж байгаа үйлдэл юм.

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Монгол Улсад автомашины нүүрсэн янданг авдаг сүлжээ үүссэн бөгөөд Бүгд Найрамдах Хятад Ард Улсруу хил нэвтрүүлэн худалдан борлуулдаг. Гаалийн Ерөнхий Газраас ирүүлсэн мэдээллээс үзэхэд 2020-2021 оны хооронд Улсын хилээр катализаторын хаягдал нэрээр 27 тонн 585 кг автомашины нүүрсэн янданг хилээр гаргасан байна. Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны жагсаалтад багтдаггүй тул хулгайн замаар болон бусад байдлаар цугларсан нүүрсэн янданг энгийн горимоор гаалийн бүрдүүлэлт хийж улсын хилээр нэвтрүүлдэг байна.

Автомашин нүүрсэн яндан болон нүүрсэн яндангийн хаягдлыг Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосноор худалдааны эргэлт нь зогсох бөгөөд үүнийг дагаад гэмт хэргийн гаралт буурна, мөн сайн дураараа худалдан борлуулдаг, үнэ дамлан зардаг үйлдэл зогсох боломжийг бүрдүүлэх юм. Ингэснээр автомашинаас ялгарч буй хорт утааны хэмжээ багасах, ялангуяа Улаанбаатар хотын тулгамдсан асуудал болсон агаар орчны бохирдол буурах бодит нөхцөл бүрдэнэ. Иймд энэхүү тогтоол нь цаг үеэ олсон маш чухал шаардлагатай тогтоолын төсөл болсон байна.

Монгол Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” 05 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт оруулж,

автомашины нүүрсэн яндан, нүүрсэн яндангийн хаягдал нэрээр улсын хилээр гаргахыг хориглох барааны жагсаалтад оруулснаар автомашины нүүрсэн янданг хулгайлах гэмт хэрэг болон сайн дураар худалдан борлуулах, дамлан зарах, улсын хилээр нэвтрүүлэх үйлдэл таслан зогсоогдох бөгөөд агаар орчны бохирдол, ялангуяа Улаанбаатар хотын хэмжээнд нүүрсэн яндангүй автомашинаас ялгарч буй утаа багасах, агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлнө. Түүнчлэн автомашины нүүрсэн янданг хууль бусаар улсын хил нэвтрүүлэгч иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйлд зааснаар Эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой болно.

ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙНЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбарын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг нь харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа:

| | Хувилбар | Зорилгод хүрэх байдал | Зардал, үр өгөөжийн харьцаа |
|---|--|---|---|
| 1 | Автомашин бүрийн нүүрсэн янданг шалган бүртгэх, кодлох. Зөрчил гаргагчид хариуцлага тооцох | Автомашин бүрийн нүүрсэн янданг бүртгэх, кодлох, зөрчил гаргагчид хариуцлага тооцох | Зардалыг хэн хариуцахаас шалтгаалж иргэд эсвэл Улсын төсвөөс их хэмжээний зардал гарна. Эрэлтийг зогсоогоогүй тохиолдолд энэ төрлийн гэмт хэрэг гарсаар байх бөгөөд цаашид нууц байдлаар үргэлжилсээр байх эрсдэлтэй. |
| 2 | Хууль тогтоомжийн төсөл боловсруулах | Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтад нэмэх | Нэмэлт зардал гарахгүй. Бүтээгдэхүүний эрэлтийг зогсоосноор энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил зогсоно. Иргэд сайн дураар худалдан борлуулах үйлдэл зогсоно. Агаарын бохирдолд үзүүлж буй нөлөөлөл буурна. |

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| Үзүүлэх үр нөлөө: | Холбогдох асуултууд | Хариулт | | Тайлбар |
|---|---|---------|-----------------------------|---|
| 1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх | 1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх | | | |
| | 1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх | Тийм | | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх | Тийм | | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 1.2. Оролцоог хангах | | | |
| | 1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх | Тийм | | Шударга ёсны зарчимд нийцсэн |
| | 1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх | Тийм | | Шударга ёсны зарчимд нийцнэ |
| | 1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага | | | |
| | 1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх | Тийм | | Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн |
| | 1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх | Тийм | | Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн. |
| 1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх | | Үгүй | энэ асуудалтай холбогдолгүй | |
| 2. Хүний эрхийг хязгаарласан | 2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх | | Үгүй | Хуулийн зорилго, шударга ёсонд нийцсэн |

| | | | | |
|---|--|------|------|---------------------------------|
| зохицуулалт агуулсан эсэх | 2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх | | Үгүй | Шаардлагагүй |
| 3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх | 5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх | Тийм | | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх | Тийм | | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| Үзүүлэх үр нөлөө: | Холбогдох асуултууд | Хариулт | | Тайлбар |
|---|---|---------|------|---------------------------------|
| 1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар | 1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан) | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал | 2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.2. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.3. Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.4. Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал | 3.1. Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.2. Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

| | | | | |
|--|--|------|------|---|
| | 3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх | Тийм | | Автомашин нүүрсэн янданг улсын хилээр гаргаж худалдан борлуулахыг хориглоно. |
| | 3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх | Тийм | | Автомашин нүүрсэн янданг улсын хилээр гаргаж худалдан борлуулдаг аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа зогсооно. |
| 4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал | 4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 5.Өмчлөх эрх | 5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 6.Инновац и болон судалгаа шинжилгээ | 6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 7.Хэрэглэгч болон гэр | 7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

| | | | | |
|---------------------------------|--|------|------|--|
| бүлийн төсөв | 7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| 8.Тодорхой бүс нутаг, салбарууд | 8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 9.Төрийн захиргааны байгууллага | 9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх | Тийм | | Зардал гарахгүй |
| | 9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх | | Үгүй | Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй |
| | 9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх | | Үгүй | Ямар нэгэн шинэ чиг үүрэг үүсгэхгүй |
| 10.Макро эдийн засгийн хүрээнд | 10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй. |
| | 10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх | | Үгүй | Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй |
| | 10.3.Инфляци нэмэгдэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 11.Олон улсын харилцаа | 11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх | Тийм | | Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй. Олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцнэ. |

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

| Үзүүлэх үр нөлөө: | Холбогдох асуултууд | Хариулт | | Тайлбар |
|--|--|---------|------|---|
| 1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл | 1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх | | Үгүй | Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй |
| | 1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | | Автомашин нүүрсэн янданг худалдан борлуулдаг, хилээр гаргаж зардаг иргэдийн бүтээгдэхүүний эрэлтийг зогсооно. |
| | 1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх | | | Үгүй |
| 2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх | 2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал | 3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

| | | | | |
|--|---|------|------|-------------------------------------|
| 4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун | 4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй |
| | 4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй |
| | 4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй |
| 5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал | 5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй |
| | 5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем | 6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. |
| | 6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал | 7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх | Тийм | | Нүүрсэн яндангийн хулгай, худалдааг |

| | | | | |
|--------|--|--|------|--------------------------------------|
| | | | | таслан зогсооно. |
| | 7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 8.Соёл | 8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх | | Үгүй | Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй |
| | 8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй |
| | 8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх | | Үгүй | Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй |

----oOo----

“ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3 дахь хэсэгт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийлээ.

Нэг.Үр нөлөөний үнэлгээний шалгуур үзүүлэлт

Улсын Их Хурлын тогтоолын төсөлд хийх үр нөлөөний үнэлгээнд тогтоолын төсөл бүхэлдээ зорилгод хүрч чадах эсэхийг тогтоохын тулд зорилгод хүрэх байдал, Засгийн газрын холбогдох байгууллага дагаж мөрдөх боломжтой эсэхийг тогтоохын тулд практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авлаа.

Хоёр.Үнэлгээ хийх хэсэг

Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь:

Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3 дахь хэсэгт “Пиво ундааны хаягдал лаазнаас бусад хаягдал хар болон өнгөт төмөрлөг /ширэм, төмөр, ган, зэс, гууль, хөнгөн цагаан, тэдгээрийн хайлш/, цутгамал болон анхдагч бусад хэлбэртэй хар болон өнгөт төмөрлөг, зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа хар болон өнгөт төмөрлөгөөр хийсэн сэлбэг, бүтээгдэхүүн, автомашины нүүрсэн яндан, нүүрсэн яндангийн хаягдал” гэсэн нэг заалттай бөгөөд уг заалтын хүрээнд үнэлгээ хийнэ.

Гурав.Шалгах хэрэгслийн дагуу тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэх

Монгол Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтыг баталсан. Уг тогтоолын 3 дахь хэсэгт “Пиво ундааны хаягдал лаазнаас бусад хаягдал хар болон өнгөт төмөрлөг /ширэм, төмөр, ган, зэс, гууль, хөнгөн цагаан, тэдгээрийн хайлш/, цутгамал болон анхдагч бусад хэлбэртэй хар болон өнгөт төмөрлөг, зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа хар болон өнгөт төмөрлөгөөр хийсэн сэлбэг, бүтээгдэхүүн”-ийг Монгол Улсын хилээр гаргахыг хориглосон. Автомашины нүүрсэн яндангийн талаар хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй, улсын хилээр чөлөөтэй нэвтрүүлж байгаагаас шалтгаалж, эрэлтийг бий болгосноос үүдэн нийгэмд олон асуудлыг үүсгээд байна.

Зам тээврийн хөгжлийн яам, Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар болон Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/-аас хийсэн судалгаанаас харахад Улаанбаатар хотын агаарын бохирдлын дунджаар 10 орчим хувийг автомашинаас үүдэлтэй бохирдол эзэлж байгаа судалгаа гарсан байна. Энэ нь жил бүр өсөх хандлагатай байгааг сүүлийн үеийн судалгаанууд харуулах боллоо.

Автомашин үйлдвэрлэгчид автомашины хөдөлгүүрээс ялгарах утаан дахь хорт бодисын хэмжээг зөвшөөрөгдөх дээд хэмжээнд хүртэл саармагжуулах

төхөөрөмжөөр автомашиныг бүрэн тоноглож эрх бүхий олон улсын хяналтын байгууллагаар сорилт, туршилт хийлгэн баталгаажуулж зах зээлд нийлүүлдэг. Энэ нь автомашины нүүрсэн яндан буюу катализатор юм. Мэргэжлийн байгууллагын ирүүлсэн мэдээллээс үзэхэд 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд 1.259.868 автомашин хөдөлгөөнд оролцож байгаагаас нийслэлд 676.974, орон нутагт 582.894 автомашин хөдөлгөөнд оролцож байна. Нийслэл хотын хэмжээнд тоёота приус маркийн 133.235 автомашин хөдөлгөөнд оролцож байна. Цагдаагийн байгууллагад сүүлийн 4 жилийн байдлаар автомашины зөөлөн яндан алдагдсан дуудлага, мэдээлэл 892 бүртгэгдсэн бөгөөд 2021 онд 129 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. хабрид автомашинуудын нүүрсэн яндангийн эд ангийг хулгайлах гэмт хэргийн гаралт нэмэгдсэн бөгөөд иргэд сайн дураараа өөрийн болон бусдын автомашины нүүрсэн янданг худалдан борлуулах, үнэ нэмж дамлан зарах үйлдэл эрх ихэссэн.

Монгол Улсад автомашины нүүрсэн янданг авдаг сүлжээ үүссэн бөгөөд Бүгд Найрамдах Хятад Ард Улсруу хил нэвтрүүлэн худалдан борлуулдаг. Гаалийн Ерөнхий Газраас ирүүлсэн мэдээллээс үзэхэд 2020-2021 оны хооронд Улсын хилээр катализаторын хаягдал нэрээр 27 тонн 585 кг автомашины нүүрсэн янданг хилээр гаргасан байна. Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны жагсаалтад багтдаггүй тул хулгайн замаар болон бусад байдлаар цугларсан нүүрсэн янданг энгийн горимоор гаалийн бүрдүүлэлт хийж улсын хилээр нэвтрүүлдэг байна.

Байгаль орчны бохирдол, хүний эрүүл мэндийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор автомашины нүүрсэн яндан, нүүрсэн яндангын хаягдал /катализатор/-ыг Монгол Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалталд нэмэлтээр оруулснаар Улсын Их Хурал нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д зааснаар эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д 1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэсэн зорилгодоо хүрэх боломж бүрдүүлж, зорилгодоо хүрч чадсан байна.

Мөн түүнчлэн тогтоолын төсөл нь практикт хэрэгжих боломжтой болох нь харагдаж байна.

Дөрөв. Зөвлөмж

Улсын Их Хурлын тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэхэд тогтоолын төсөл батлагдсан тохиолдолд зорилгодоо хүрэх байдал нь эерэг, тухайн зохицуулалтыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэж байна.

Иймд тогтоолын төслийг хэвээр үлдээхийг зөвлөж байна.

-----o0o-----

**“УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОХ, ТАРИФЫН БУС БУСАД
ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХ БҮЛЭГ БАРААНЫ ЖАГСААЛТЫГ БАТЛАХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН 1998 ОНЫ 05 ДУГААР ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД
НЭМЭЛТ ОРУУЛСНААР ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

“Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3 дахь хэсгийн “зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа хар болон өнгөт төмөрлөгөөр хийсэн сэлбэг, бүтээгдэхүүн” гэсний дараа “Автомашинны нүүрсэн яндан, нүүрсэн яндангийн хаягдал” гэж нэмсэн тогтоолын төсөл батлагдсанаар түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Энэхүү үнэлгээний зорилго нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцож, улмаар холбогдох ачааллыг багасгах, зардлыг бууруулах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг тооцоход:

1.төрийн байгууллагын зардал;

2.хуулийн этгээдийн зардал;

3.иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог боловч тус Улсын Их Хурлын тогтоолын төслөөр хувь хүн, төрийн байгууллага, хуулийн этгээдэд ямар нэгэн нэмэлт үүрэг хүлээлгээгүй тул хуулийн хэрэгжилттэй холбоотой тэдгээрээс нэмэлт зардал шаардахгүй.

-----oOo-----



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН С.БЯМБАЦОГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

14201 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Самбуугийн гудамж 18, Утас: 7019-1087, Факс: 7019-1087,
Web: www.police.gov.mn, E-mail: info@police.gov.mn

᠘᠒᠘᠘.᠐᠕.᠔᠘ № ᠐1/᠘᠙᠑
танай ᠒᠐᠒᠒.᠐3.᠒᠑ -ны № ᠑᠘᠕-᠐3/᠒841-Т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Улсын хэмжээнд тээврийн хэрэгслийн нүүрсэн яндантай холбоотой үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн талаарх судалгаа, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаарх саналыг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэргийн талаар

Энэ оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд 1.259.868 автомашин хөдөлгөөнд оролцож байгаагаас нийслэлд 676.974 /53.7 хувь/, орон нутагт 582.894 /46.3 хувь/ байна.

Нийслэл хотын хэмжээнд Toyota prius маркийн автомашин 133.235 /10.5 хувь/ хөдөлгөөнд оролцож байгаа судалгаа гарсан.

| Д/д | Марк, төрөл | Тоо | Хувь |
|-----|-----------------|--------|------|
| 1 | Toyota prius-20 | 67.456 | 50.6 |
| 2 | Toyota prius-30 | 50.631 | 38.0 |
| 3 | Toyota prius-40 | 15.148 | 11.3 |

Цагдаагийн байгууллагад сүүлийн 4 жилийн байдлаар Toyota prius маркийн автомашины зөөлөн яндан алдагдсан дуудлага, мэдээлэл 892 бүртгэгдсэн бөгөөд 2021 онд 129, 2022 оны нэгдүгээр улирлын байдлаар 19 гэмт хэрэг байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас агаарын бохирдол, утаатай тэмцэх зорилгоор утаа их хаядаг автомашиныг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх хууль гарч, сайн шүүлтүүртэй яндангийн эрэлт хэрэгцээ нэмэгдсэн нь эдэлгээ удаантай, шүүлтүүр сайтай элемент агуулдаг Япон Улсад үйлдвэрлэгдсэн hybrid автомашинуудын нүүрсэн яндангийн эд ангийг хулгайлах гэмт хэргийн гаралт нэмэгдсэн.

**Хоёр. Орчны бохирдлын болон хэрэгжүүлж буй ажил,
арга хэмжээ, саналын талаар**

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны Ажлын албаны дарга нарын 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/20 дугаар тушаалаар "Тээврийн хэрэгслийн нүүрсэн яндантай холбогдох хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, түүнд тавих хяналтыг сайжруулах, Монгол Улсын хилээр гаргахыг хориглосон бараа бүтээгдэхүүний жагсаалтад оруулах" үүрэг бүхий Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, Гаалийн ерөнхий газар, Авто тээврийн газар, Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх

15᠑᠒ 06 1508

газар, Цагдаагийн ерөнхий газрын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Автозамын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн нүүрсэн яндан буюу катализаторын ажиллагааны байдлыг тодорхойлох зорилгоор Монгол Улсын автозамын хөдөлгөөнд хамгийн их оролцож байгаа Toyota prius маркийн автомашиныг сонгож, Стандартчилал, хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2009 оны 15 дугаар тогтоолоор баталсан "Бензин хөдөлгүүртэй автомашин-утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга" MNS:5013:2009 стандартад тулгуурлан үйлдвэрийн яндантай, БНХАУ-д үйлдвэрлэсэн яндантай, яндангүй гэсэн 3 төрлийн нөхцөлд тээврийн хэрэгслийн яндангаас хаягдаж буй бохирдуулах бодисын хэмжээг хэмжиж, харьцуулалт хийсэн.

Хэмжилтийн үр дүнд үйлдвэрийн яндантай тээврийн хэрэгслээс агаарт хаягдах СО /нүүрстөрөгчийн дутуу исэл/-ийн хэмжээ яндангүй тээврийн хэрэгслээс хаягдаж буй хэмжээнээс 4.5 дахин бага байна.

Харин БНХАУ-д үйлдвэрлэсэн яндангаас 3.2 дахин бага байсан бол их эргэлттэй үед СО /нүүрстөрөгчийн дутуу исэл/-ийн хэмжээ үйлдвэрийн яндангаас ялгарах хэмжээ яндангүй тээврийн хэрэгслээс 6.8, БНХАУ-д үйлдвэрлэсэн яндангаас 4.3 дахин бага ялгаралттай гэсэн дүгнэлт гарчээ.

Авто тээврийн үндэсний төвд хийсэн нүүрсэн яндангүй тээврийн хэрэгслээс ялгарч байгаа хорт утааны чанар байдлын С, НС-ийн дүгнэлтийг үндэслэн Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх газраас гэмт хэргийн улмаас нүүрсэн яндангаа хулгайд алдсан 892 тээврийн хэрэгслээс ялгарч байгаа хорт утааны хоруу чанар байдлын талаар мэдээлэл авахад нүүрстөрөгчийн дутуу исэл 2230, нүүрс-устөрөгчийн хувьд 446, нийт 2676 гр хоруу чанар өндөртэй хорт утаа ялгаруулж байна.

Дээрх судалгаанаас үндэслэн нүүрсэн яндангүй тээврийн хэрэгслээс ялгаруулж байгаа хорт утаа нь агаар орчны бохирдолд нөлөөлөх, хүний бие эрүүл мэндэд хохирол учруулж байгаа хоруу чанар өндөр байна гэж дүгнэсэн.


Иймд дээр дурдсан хорт бодисыг шүүхэд нүүрсэн яндан буюу катализатор нь чухал үүрэгтэй тул тээврийн хэрэгслийн техникийн үзлэг, оношилгооны үед яндангийн байдлыг харгалзах зайлшгүй шаардлагатай байна.

Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны Ажлын албаны дарга нарын 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/20 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд Хосолсон хөдөлгүүртэй /Hybrid/ автомашины нүүрсэн янданг Монгол Улсын хилээр гаргахыг хориглосон бараа бүтээгдэхүүний жагсаалтад оруулах, Монгол Улсын хилээр орж ирж байгаа хосолсон хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн янданд тавигдах стандартыг боловсруулан, түүнд тавих хяналтыг сайжруулах зэрэг саналтай байгааг танилцуулья.

Хүндэтгэсэн,

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг.

Барилгачдын талбай 13, Засгийн газрын XII байр,

Утас: 26-47-86, Факс: (976-51) 26-60-88

E-mail: info@inspection.gov.mn, http://www.inspection.gov.mn

2022. 04. 29 № 01/852


танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.БЯМБАЦОГТ ТАНАА**

Танаас ирүүлсэн 2022 оны УИХ-03/2845 тоот албан бичигт заасны дагуу автомашинаас ялгарах утаа агаар орчинд үзүүлэх нөлөөллийн судалгаа, нүүрсэн яндан, түүний ач холбогдол, хууль бус худалдаа, зөрчлийн эсрэг цаашид авах арга хэмжээний талаарх мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА



Б.БААСАНДОРЖ

1522001190

АВТОМАШИНААС ЯЛГАРАХ УТАА АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ, НҮҮРСЭН ЯНДАН, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, САНАЛ

Нэг. Ерөнхий мэдээлэл

Монгол улсын хэмжээнд 2022 оны 04 дүгээр сарын байдлаар нийт 1264309 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэнээс нийслэлд 679574 тээврийн хэрэгсэл, орон нутагт 584735 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн байна. Үүнээс улсын хэмжээнд бензин хөдөлгүүртэй 536575, дизель хөдөлгүүртэй 323188, цахилгаан 518, хийн 25167, хосолсон 296380 тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцож байна.

Хоёр. Автомашинаас ялгарах утаа агаар орчинд үзүүлэх нөлөөлөл, судалгаа

Зам тээврийн хөгжлийн яам, Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газар болон Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/-аас 2016-2018 онд хийсэн судалгаагаар Улаанбаатар хотын агаарын бохирдлын дунджаар 10 хувийг автомашинаас үүдэлтэй бохирдол эзэлж байна гэж үзсэн байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хийсэн тандалт судалгааны дүнгээр улсын хэмжээнд 2020 оноос 2022 оны 1 улирлын байдлаар техникийн хяналтын үзлэгт давхардсан тоогоор 1612091 тээврийн хэрэгсэл хамрагдсан ба эдгээрээс хосолсон хөдөлгүүр бүхий /катализатор/-тай тээврийн хэрэгсэл 496709 буюу 30.8%-ийг эзэлж байна.

Сүүлийн 3 жилийн байдлаар 30908 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт тэнцээгүй байгаагаас үүний 13.4% буюу 4143 тээврийн хэрэгслийн утааны найрлага дахь хорт бодис болон утааны тортогжилт нь стандартаар тогтоосон зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн байна. Үзлэгээр 3191 тээврийн хэрэгсэл нүүрсэн яндан /катализатор/-гүйгээс техникийн хяналтын үзлэгт тэнцээгүй байгаа бөгөөд энэхүү зөрчлийн 40.5 %-ийг арилгасан байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас нийслэлийн хэмжээнд 2019 оноос 2021 онуудад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар 41 аж ахуйн нэгж, байгууллага болон 270 иргэний 661 автотээврийн хэрэгслийн хаягдал утаанд хэмжилт хийхэд 348 буюу 52.6% нь стандартын шаардлага хангаагүй зөрчил илрүүлсэн бөгөөд зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 9 албан шаардлага, 21 зөвлөмж, 11 эрх бүхий албан тушаалтны даалгавар хүргүүлж, зөрчил гаргасан хуулийн этгээд, иргэдэд 15.000.0 мян.төгрөгийн шийтгэлийн арга хэмжээг авч, сургалтыг зохион байгуулсан.

Мэргэжлийн хяналтын байгууллагад бензин хөдөлгүүртэй автомашины яндангийн утаанд хэмжилт хийх багажгүй тул Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны санхүүжилтээр 2022 онд багаж худалдан авах захиалга өгч гэрээ байгуулан ажиллаж байна.

Гурав. Нүүрсэн яндан /катализатор/, түүний ач холбогдол

Катализаторыг ихэвчлэн бензин эсвэл дизель түлшээр ажилладаг дотоод шаталтын хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэлд ашигладаг. Бүтэц нь халуунд тэсвэртэй гангаар хийгдсэн гэр дотор зөгийн үүр шиг хэлбэртэй исэлдүүлэгчийг байрлуулсан

байдаг. Энэ нь утаан дахь хүний биеийн эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хор нөлөөтэй хүчилтөрөгчийг нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) болон шатаагүй нүүрс устөрөгчид (CH) -тай нэгтгэж, нүүрстөрөгчийн давхар исэл (CO₂) болон ус (H₂O) болгон цэвэршүүлэх, азотын ислийг (NO_x) бууруулж агаарт ялгаруулах үүргийг гүйцэтгэдэг. Катализатор нь ажилласан хийн найрлага дахь хорт бодисын хэмжээг багасгах ач холбогдолтой.

Катализатор дотор хатуу ган болох цагаан алт, паллади, хөнгөн цагааны исэл зэрэг үнэт металл агуулагддаг.

Дөрөв. Цаашид авах арга хэмжээний талаарх санал

Нүүрсэн яндан /катализатор/-гүй автотээврийн хэрэгсэл нь агаарын бохирдлыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх сөрөг үр дагавар ихтэй учир тодорхой шийдлүүд гаргаж таслан зогсоох арга хэмжээг шат дараалалтайгаар авч хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна. Үүнд:

1. Нүүрсэн яндантай холбоотой ил, далд бизнесийг хязгаарласан хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх; /Хил гаалиар гаргахгүй бараа материалын жагсаалтад оруулах/
2. Замын хөдөлгөөнд оролцож байгаа эрсдэл өндөр загварын /ялангуяа toyota prius маркийн/ тээврийн хэрэгслүүдийн нүүрсэн яндангийн ашиглалтын байдлыг тогтоох болон хаягдал утаанд хэмжилт хийх ажлыг эрчимжүүлэх;
3. Стандартын шаардлага хангахгүй нүүрсэн яндантай тээврийн хэрэгслийг илрүүлж, хөдөлгөөнд оролцох эрхийг хязгаарлаж, арга хэмжээ тооцох;
4. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн үйл ажиллагааг сайжруулах;
5. Евро 5 стандартын дизель түлшинд шилжих, үүнээс бага стандарттай шатахууныг хэрэглэхийг хориглох;
6. Иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр катализаторын талаар мэдээллийг хүргэж, сурталчлах;
7. Монгол улсын хил гаалиар катализаторгүй тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхгүй байх;
8. Автомашины тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан автомашины ялгарлаас үүдэлтэй агаарын бохирдлын нөлөөллийн судалгааг шинэчлэн тогтоох ажлыг салбарын байгууллагуудын хүрээнд хэрэгжүүлэх зэрэг болно.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

14193 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,

Их тойруу 81/1. Утас/Факс: (976-11) 35 00 60.

И-мэйл: info@customs.gov.mn. Вэбсайт: www.customs.gov.mn

2022. 04. 14 № 02/1004

танай 2022. 03. 29 -ны № Уух-03/2944-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН С.БЯМБАЦОГТ ТАНАА


Мэдээлэл хүргүүлэх тухай

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнийн 2022 оны 03-р сарын 25-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын алба, Эрүүгийн цагдаагийн алба, Гаалийн ерөнхий газар, Авто тээврийн үндэсний төв, Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх газрын алба хаагчдаас бүрдсэн Тээврийн хэрэгслийн нүүрсэн яндантай холбогдох хууль эрх зүйн орчин түүнд тавих хяналтыг сайжруулах, Монгол Улсын хилээр гаргахыг хориглосон бараа бүтээгдэхүүний жагсаалтад тээврийн хэрэгслийн нүүрсэн янданг оруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Гаалийн байгууллага байгаль орчны бохирдол, хүний эрүүл мэнд хохирох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор автомашины нүүрсэн яндан /катализатор/-ыг Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 54 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт "Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны кодлосон жагсаалт"-д оруулж улсын хилээр гаргахыг хориглох саналтай байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн автомашины нүүрсэн яндан /катализатор/-ын мэдээллийг гаалийн мэдүүлгийн сангаас гарган хавсралтаар үүгээр уламжилж байна.

Хавсралт 2 хуудастай.

ДЭД ДАРГА




Ц.ГЭНДЭНЦЭВЭЭН

1439507 1240

2017.01.01-2021.12.31-ний хугацаанд 7112.99.00 БТКУС-ын нэрээр тавийн мэдүүлгээр бүрдүүллт хийсэн мэдээлэл

| Он | Хугацаа (сая.төг) | Илгээгч | Агуулга (английн үг) | Зарчиг (төгрөг) | Тайлбар | Сая.төг | Тайлбар |
|------|-------------------|---------|---------------------------|------------------------|--|----------|---------------|
| 2020 | 100 | Монгол | Сигнаур | Катализаторын хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.01%, цэрэс-1.99%, ванадий-0.14%, нитробензол-0.12%, төмөр-0.21%, тус бүр агуулсан, жорин металлээр хийсэн, үст металл галлагч-ээр бүрсэн, автошашины илчлэгийн шингэлдсэн, палладийн 0.05%, нитробензол-0.08%, төмөр-0.15%, жонин цагаан-0.71%, цагаар-0.07%, цайр-1811мкг, ниваль-89мкг агуулагдсан, жорин металлээр хийсэн, үст металл галлагч-ээр бүрсэн, автошашины илчлэгийн шингэлдсэн, цэцээн алт-818.5мкг, палладийн 478.5мкг, цэцээн алт-17.31%, жонин цагаан-18.96%, төмөр-0.90%, ниваль-189.5мкг, нитробензол-20.57мкг, цайр-1001мкг тус бүр агуулагдсан, жорин металлээр хийсэн, үст металл галлагч-ээр бүрсэн, автошашины илчлэгийн шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 302.30 | 30.598,005.15 |
| 2020 | 100 | Монгол | Сигнаур | Катализаторын хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.05%, нитробензол-0.08%, төмөр-0.15%, жонин цагаан-0.71%, цагаар-0.07%, цайр-1811мкг, ниваль-89мкг агуулагдсан, жорин металлээр хийсэн, үст металл галлагч-ээр бүрсэн, автошашины илчлэгийн шингэлдсэн, цэцээн алт-818.5мкг, палладийн 478.5мкг, цэцээн алт-17.31%, жонин цагаан-18.96%, төмөр-0.90%, ниваль-189.5мкг, нитробензол-20.57мкг, цайр-1001мкг тус бүр агуулагдсан, жорин металлээр хийсэн, үст металл галлагч-ээр бүрсэн, автошашины илчлэгийн шингэлдсэн, палладийн 0.01%, цэрэс-1.97%, ванадий-0.16%, нитробензол-0.16%, цайр-0.01%, төмөр-0.17%, ниваль-0.88%, жонин цагаан-2.85%, тус бүр агуулсан, жорин металлээр хийсэн, үст металл галлагч-ээр бүрсэн, автошашины илчлэгийн шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 695.90 | 46,778,692.39 |
| 2020 | 100 | Монгол | Сигнаур | Катализаторын хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 740.50 | 17,690.55 |
| 2020 | 100 | Монгол | Сигнаур | Шүүгүүрийн хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 1,889.70 | 45,144.93 |
| 2021 | 100 | Монгол | Нэгдсэн Арабын Эмират Улс | Катализаторын хэргэлэл | Торон нээхтэй саврал өмчийн нунтаг, шингэлдсэн, палладийн-30.16мкг, цэцээн алт-1305мкг, цэцээн алт-14.24%, төмөр-0.13%, жонин цагаан-19.27%, ниваль-10.73мкг, цайр-253мкг, нитробензол-2.55мкг тус тус агуулсан, жорин металлээр хийсэн | 554.95 | 13,257.76 |
| 2021 | 100 | Монгол | Нэгдсэн Арабын Эмират Улс | Катализаторын хэргэлэл | Торон нээхтэй саврал өмчийн нунтаг, шингэлдсэн, палладийн-42.1мкг, цэцээн алт-1130мкг, цайр-1.35мкг, жонин цагаан-19.76%, төмөр-0.19%, цэцээн алт-13.4%, цайр-30.97мкг, ниваль-11.39мкг, цайр-2.55мкг тус тус агуулсан, жорин металлээр хийсэн | 753.05 | 17,990.37 |
| 2021 | 100 | Монгол | Нэгдсэн Арабын Эмират Улс | Катализаторын хэргэлэл | Торон нээхтэй саврал өмчийн нунтаг, шингэлдсэн, палладийн-2234мкг, цэцээн алт-1160мкг, цэцээн алт-13.77%, төмөр-0.19%, жонин цагаан-21.00%, ниваль-21.91мкг, цайр-43.64мкг, цайр-313мкг тус тус агуулсан, жорин металлээр хийсэн | 752.05 | 17,966.48 |
| 2021 | 100 | Монгол | Сигнаур | Катализаторын хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.01%, цэрэс-1.97%, ванадий-0.20%, нитробензол-0.16%, цайр-0.01%, төмөр-0.17%, ниваль-0.88%, жонин цагаан-2.85%, тус бүр агуулсан, жорин металлээр хийсэн, үст металл галлагч-ээр бүрсэн, автошашины илчлэгийн шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 356.90 | 8,528.35 |
| 2021 | 100 | Монгол | Сигнаур | Катализаторын хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 372.40 | 8,896.64 |
| 2021 | 100 | Монгол | Сигнаур | Катализаторын хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 449.50 | 10,738.58 |
| 2021 | 100 | Монгол | Сигнаур | Катализаторын хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 749.75 | 17,911.53 |
| 2021 | 100 | Монгол | Сигнаур | Катализаторын хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 833.25 | 43,098,993.66 |
| 2021 | 100 | Монгол | Сигнаур | Катализаторын хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 474.16 | 11,327.44 |
| 2021 | 100 | Монгол | Сигнаур | Катализаторын хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 471.85 | 11,272.50 |
| 2021 | 100 | Монгол | Сигнаур | Катализаторын хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 710.00 | 18,961.91 |
| 2021 | 100 | Монгол | Сигнаур | Катализаторын хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 1,056.30 | 25,211.12 |
| 2021 | 100 | Монгол | Сигнаур | Катализаторын хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 757.00 | 18,084.73 |
| 2021 | 100 | Монгол | Сигнаур | Катализаторын хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 732.50 | 17,489.43 |
| 2021 | 100 | Монгол | Сигнаур | Катализаторын хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 766.55 | 18,838.48 |
| 2021 | 100 | Монгол | Сигнаур | Катализаторын хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 678.75 | 16,239.23 |
| 2021 | 100 | АНУ | АНУ | Катализаторын хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 500.00 | 15,000.00 |
| 2021 | 100 | Монгол | Сигнаур | Катализаторын хэргэлэл | Шингэлдсэн, палладийн 0.13%, төмөр-0.07%, жонин цагаан-13.28%, цэцээн алт-1740мкг, жонин цагаан-18.96%, жонин цагаан-18.96% | 500.00 | 42,736,350.00 |



| | | | | | | | | |
|------|-----|--------|--------|--------------------------|--|-----------|------------|------------------|
| 2021 | 100 | Монгол | АНУ | Каталлизаторын хаягдал | Уучин, шилтгэгдсэн, савалгаас: 10x23.06г, автомашины нүдэнгийн шүүлтүүрийн торон нэвээстэй саврал өнгөтэй | 230.80 | 6,924.00 | 19,724,808.52 |
| 2021 | 100 | Монгол | АНУ | Каталлизаторын хаягдал | Уучин, шилтгэгдсэн, савалгаас: 71x43.51г, автомашины нүдэнгийн шүүлтүүрийн торон нэвээстэй саврал өнгөтэй | 482.00 | 19,290.00 | 54,932,190.40 |
| 2021 | 100 | Малайз | Малайз | Каталлизаторын хаягдал | Шинэилсгэсэн Аугустус үзэгдэ туушмын эхпортологч буй бараа нь | 1,021.60 | 44,514.00 | 125,900,584.57 |
| 2021 | 100 | Монгол | Малайз | Каталлизаторын хаягдал | Шинэилсгэсэн Аугустус үзэгдэ туушмын эхпортологч буй бараа нь | 438.80 | 13,164.00 | 37,500,590.08 |
| 2021 | 100 | Монгол | Малайз | Каталлизаторын өөрсөс эг | шилтгэгдсэн, савалгаас: 10.38г, автомашины нүдэнгийн шүүлтүүрийн торон нэвээстэй саврал өнгөтэй | 260.40 | 16,824.00 | 47,945,203.44 |
| 2021 | 100 | Монгол | Малайз | Каталлизаторын өөрсөс эг | шилтгэгдсэн, савалгаас: 11.4г, автомашины нүдэнгийн шүүлтүүрийн торон нэвээстэй саврал өнгөтэй | 342.00 | 20,520.00 | 58,466,810.00 |
| 2021 | 100 | Монгол | Малайз | Каталлизаторын өөрсөс эг | шилтгэгдсэн, савалгаас: 63.2г, автомашины нүдэнгийн шүүлтүүрийн торон нэвээстэй саврал өнгөтэй | 316.00 | 16,624.00 | 47,945,203.14 |
| 2021 | 100 | Монгол | Малайз | Каталлизаторын хаягдал | шилтгэгдсэн, савалгаас: 12x29.23г, 28x33.75г, 1x39.5г, автомашины нүдэнгийн шүүлтүүрийн торон нэвээстэй саврал өнгөтэй | 1,364.50 | 54,590.00 | 155,535,534.40 |
| 2021 | 100 | Монгол | Малайз | Каталлизаторын хаягдал | шилтгэгдсэн, савалгаас: 9x4.33г, автомашины нүдэнгийн шүүлтүүрийн торон нэвээстэй саврал өнгөтэй | 399.00 | 15,960.00 | 45,482,967.80 |
| 2021 | 100 | Монгол | Малайз | Каталлизаторын хаягдал | Уучин, шилтгэгдсэн, савалгаас: 77x31.07г, автомашины нүдэнгийн шүүлтүүрийн торон нэвээстэй саврал өнгөтэй | 541.80 | 19,254.00 | 48,303,257.42 |
| 2021 | 100 | Монгол | Малайз | Каталлизаторын хаягдал | Уучин, шилтгэгдсэн, савалгаас: 21x31.01г, автомашины нүдэнгийн шүүлтүүрийн торон нэвээстэй саврал өнгөтэй | 851.30 | 19,539.00 | 55,868,059.84 |
| 2021 | 100 | Монгол | Малайз | Каталлизаторын хаягдал | Уучин, шилтгэгдсэн, савалгаас: 30x33.36г, автомашины нүдэнгийн шүүлтүүрийн торон нэвээстэй саврал өнгөтэй | 1,001.00 | 30,030.00 | 85,545,860.40 |
| 2021 | 100 | Монгол | Малайз | Каталлизаторын хаягдал | Уучин, шилтгэгдсэн, савалгаас: 33x33.07г, автомашины нүдэнгийн шүүлтүүрийн торон нэвээстэй саврал өнгөтэй | 1,091.40 | 43,656.00 | 124,366,776.24 |
| 2021 | 100 | Монгол | Малайз | Каталлизаторын хаягдал | Уучин, шилтгэгдсэн, савалгаас: 49x31.56г, автомашины нүдэнгийн шүүлтүүрийн торон нэвээстэй саврал өнгөтэй | 1,547.70 | 61,908.00 | 176,384,559.12 |
| 2021 | 100 | Монгол | Малайз | Каталлизаторын хаягдал | Уучин, шилтгэгдсэн, савалгаас: 62x33.03г, автомашины нүдэнгийн шүүлтүүрийн торон нэвээстэй саврал өнгөтэй | 1,993.00 | 79,720.00 | 227,116,699.00 |
| 2021 | 100 | Монгол | Малайз | Каталлизаторын хаягдал | Шинэилсгэсэн Аугустус үзэгдэ туушмын эхпортологч буй бараа нь хаягдал байна. | 1,474.80 | 44,244.00 | 128,037,373.14 |
| | | | | Дүн | | 27,995.45 | 881,235.40 | 2,425,392,885.84 |

Горнинын тайлбар:

100- Гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэнд байгаа монголын барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
С.БЯМБАЦОГТ ТАНАА

АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ОМЧИГ ҮЙЛДВӨРИЙН ГАЗАР

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас/Факс: (976) 7012-7042

᠑᠒᠑᠑.᠐4.19 № 1/4᠑6
танай 2᠘᠒.᠘3.29-ны № ᠑/ИХ-᠒3/2846 -т

Хариу хүргүүлэх тухай

"Монгол Улсын хэмжээнд болон Улаанбаатар хотод замын хөдөлгөөнд оролцож буй автомашины тоо², авто машины техникийн стандартад тавигдах ерөнхий шаардлага¹, авто машинаас ялгарах утаа нь агаар, орчинд үзүүлж буй нөлөөллийн талаарх судалгаа³, авто машины нүүрсэн яндангийн зориулалт, ач холбогдол⁴ болон тус зөрчлийн эсрэг цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал ирүүлэх⁵" тухай албан бичигтэй танилцлаа.

1."Авто машины техникийн стандартад тавигдах ерөнхий шаардлага"-ын мэдээллийг дараах стандартыг агуулсан холбоосноос авах боломжтой.
Монгол улс авtotээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах ерөнхий шаардлагыг MNS 4598:2011 стандартад тусган, мөрдөж байна.

https://mrt.d.gov.mn/up/news/Standart_Normativ/4598-2011.pdf

2.Монгол Улсын хэмжээнд болон Улаанбаатар хотод замын хөдөлгөөнд оролцож буй автомашины тоо"-ны талаарх мэдээллийг хавсралт 1-ээр,

3."Авто машинаас ялгарах утаа нь агаар, орчинд үзүүлж буй нөлөөллийн талаарх" ерөнхий мэдээллийг хавсралт 2-оор,
Автомашинаас ялгарах утааны агаар, орчинд үзүүлэх нөлөөллийн судалгааг "Нийслэлийн агаар, орчинтой тэмцэх газар" төлөвлөгөөт хугацаанд тогтмол хийж гүйцэтгэдэг.

Иймд НАОТГ-т хандан холбогдох нарийвчилсан мэдээлэл, судалгааны ажлыг авна уу.

4."Авто машины нүүрсэн яндангийн зориулалт, ач холбогдол"-ийн талаарх мэдээллийг хавсралт 3-аар,

5."Тус зөрчлийн эсрэг цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал"-ыг хавсралт 4-өөр тус тус хүргүүлж байна.

Хавсралт...хуудастай.

ЗАХИРАЛ

Б.ГҮРСОРОНЗОН

᠑᠒᠑᠑᠐᠐4᠑5

1. Монгол Улсын хэмжээнд болон Улаанбаатар хотод замын хөдөлгөөнд оролцож буй автомашины тоо.

Монгол улсын автотээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн санд 2021 оны байдлаар 30 улсаас импортлогдсон 1243445 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна.

Хүснэгт 1. Тээврийн хэрэгслийн төрөл, тоо- Бүртгэгдсэн оноор

| | 2019 | 2020 | 2021 |
|--------------------|----------------|----------------|----------------|
| СУУДЛЫН АВТОМАШИН | 667375 | 709498 | 782210 |
| АЧААНЫ АВТОМАШИН | 203675 | 209154 | 226364 |
| АВТОБУС | 19535 | 36178 | 34211 |
| ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН | 13582 | 13440 | 16228 |
| ЦИСТЕРН | 6493 | 7108 | 4233 |
| ЗҮТГҮҮР | 23850 | 29422 | 38523 |
| МЕХАНИЗМ | 13595 | 14882 | 16596 |
| ЧИРГҮҮЛ | 47972 | 39581 | 53290 |
| МОТОЦИКЛ | 46951 | 67513 | 71790 |
| | 1043028 | 1126776 | 1243445 |

Эх сурвалж: ЗТХЯ-Тээврийн хэрэгслийн статистик

Нийт тээврийн хэрэгслийн 668397 буюу 53.7% нь Улаанбаатар хотод, 575048 буюу 46.3% нь орон нутагт бүртгэлтэй байх ба бүртгэлтэй 1243445 тээврийн хэрэгслийн 88.6 % нь буюу 1.101.719 автомашин, 5.8% нь буюу 71790 мотоцикл, 4.3% буюу 53290 чиргүүл, 1.3% нь буюу 16596 механизм байна.

Нийт тээврийн хэрэгслийн 64% нь Япон улсаас импортлогдсон бол 36% нь Хятад, Солонгос, Герман болон бусад улс орноос импортлогдсон байна.

- Хятад улсаас 19%
- Солонгос улсаас 13%
- Герман улсаас 1%
- Орос улсаас 1%
- Бусад улсаас 2% /Англи, Америк, Белги гэх мэт.

Монгол улсын хэмжээнд 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 779908 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдсанаас 724501 автомашин, 55407 механизм, чиргүүл, мотоцикл байна.

Эдгээрийн 44.5% нь буюу 346705 орон нутагт, 55.5% нь буюу 433203 Улаанбаатар хотод техникийн хяналтын үзлэгт хамрагдсан байна.

Сүүлийн 3 жилийн байдлаар буюу 2019, 2020, 2021 онуудад дунджаар 660 мянга гаруй автомашин, 50 мянга гаруй механизм, чиргүүл, мотоцикл техникийн хяналтын үзлэгт хамрагдсан байна.

Үүнээс үзэхэд Улаанбаатар хотод 400-450 мянга гаруй, орон нутагт 300-350 мянга орчим нийт 700-800 мянган тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт тогтмол хамрагдаж, замын хөдөлгөөн идэвхтэй оролцдог болох нь харагдаж байна.

Хүснэгт 2. Техникийн хяналтын үзлэгт орсон тээврийн хэрэгслийн тоо-Сүүлийн 3 жилийн байдлаар /Үзлэгт орсон газар, хөдөлгүүр, насжилт, тх-ийн төрлөөр/

| ҮЗЛЭГТ ОРСОН ГАЗАР-2021 | Тээврийн хэрэгсэл-төрлөөр | | Хөдөлгүүрийн төрлөөр | | | | | Насжилтаар | | | |
|-------------------------------|------------------------------|-------------|----------------------|---------|-------|---------------|--------------|------------|------------|---------|---------------|
| | Автомашин | Бусад ТХ | Бензин | Дизель | Хий | Цахил гаан | Хосол сон | 0-3 жил | 4-6 жил | 7-9 жил | 10 ба дээш |
| Орон нутагт | 304887 | 41818 | 123,415 | 121,121 | 6,810 | 50 | 64,738 | 20,279 | 9,556 | 17,036 | 299,834 |
| Улаанбаатарт | 419614 | 13589 | 151919 | 83005 | 8564 | 269 | 182651 | 9486 | 13286 | 45756 | 364675 |
| | 724501 | 55407 | 275334 | 204126 | 15374 | 319 | 247389 | 29765 | 22842 | 627792 | 664509 |

| ҮЗЛЭГТ ОРСОН ГАЗАР-2020 | Тээврийн хэрэгсэл-төрлөөр | | Хөдөлгүүрийн төрлөөр | | | | | Насжилтаар | | | |
|-------------------------------|------------------------------|-------------|----------------------|---------|-------|---------------|--------------|------------|------------|---------|---------------|
| | Автомашин | Бусад ТХ | Бензин | Дизель | Хий | Цахил гаан | Хосол сон | 0-3 жил | 4-6 жил | 7-9 жил | 10 ба дээш |
| Орон нутагт | 274232 | 36641 | 123,364 | 110,137 | 6,455 | 38 | 48,540 | 11,473 | 9,499 | 11,354 | 278,547 |
| Улаанбаатарт | 375384 | 14496 | 143423 | 78075 | 8993 | 242 | 151403 | 7698 | 9008 | 35797 | 337377 |
| | 649616 | 51137 | 266787 | 188212 | 15448 | 280 | 199943 | 19171 | 18507 | 47151 | 615924 |

| ҮЗЛЭГТ ОРСОН ГАЗАР-2019 | Тээврийн хэрэгсэл-төрлөөр | | Хөдөлгүүрийн төрлөөр | | | | | Насжилтаар | | | |
|-------------------------------|------------------------------|-------------|----------------------|---------|-------|---------------|--------------|------------|------------|---------|---------------|
| | Автомашин | Бусад ТХ | Бензин | Дизель | Хий | Цахил гаан | Хосол сон | 0-3 жил | 4-6 жил | 7-9 жил | 10 ба дээш |
| Орон нутагт | 249803 | 33522 | 114,757 | 104,114 | 6,437 | 25 | 37,053 | 3,399 | 10,414 | 8,567 | 260,946 |
| Улаанбаатарт | 389829 | 12545 | 149,938 | 78,415 | 9,563 | 207 | 137,401 | 5,008 | 7,903 | 24,653 | 344,810 |
| | 619632 | 46067 | 264695 | 182529 | 16000 | 232 | 174454 | 8407 | 18317 | 33220 | 605756 |

Эх сурвалж: АТҮТ- АТХБМСан

2. “Авто машинаас ялгарах утаа нь агаар, орчинд үзүүлж буй нөлөөллийн талаарх судалгаа”.

Дотоод шаталтад хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл нь хүрээлэн буй орчинд ялангуяа агаарын орон зайг бохирдуулагчийн нэг бөгөөд түүний ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой сөрөг үр дагавруудыг бууруулах нь өнөөгийн тулгамдсан асуудал болоод байна. Энэ чиглэлээр Монгол улсад 1998 оноос эхлэн холбогдох судалгааны ажлуудыг хийж эхэлсэн байна.

“Улаанбаатар хотод автомашин ашиглалтын экологийн сөрөг үр дагаврын судалгаа” (1998-2000 он)

ЭТМС Нэгдэл, УЦУОШГ, Байгаль орчны шинжилгээний төв лаборатори хамтран “Улаанбаатар хотод автомашин ашиглалтын экологийн сөрөг үр дагаврын судалгаа”-г хийсэн бөгөөд судалгаагаар Улаанбаатар хотод бүртгэлтэй нийт 41.000 автомашинаас түүвэрлэн ажиглалт хийсэн. Судалгаагаар бензин хөдөлгүүртэй автомашины 50% нь угаарын хий СО-ийн агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн, 20% нь угаарын хий зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 2 дахин өндөр үзүүлэлттэй гарсан байна. 2000 онд нийт автомашины 50% нь үйлдвэрлэгдээд 11-ээс дээш жил

ашиглагдсан байсан бөгөөд автомашины парк хэт хуучирсан, хуучин автомашины импорт нэмэгдсэн, стандартын шаардлага хангаагүй тос, тосолгооны материалыг импортлох түүнийг хяналтгүйгээр хэрэглэх явдал түгээмэл байна гэсэн дүгнэлт гарсан байна. Мөн автосервис хөгжөөгүй, техникийн үйлчилгээ, засварын чанар муу, автомашины техникийн хяналтын систем зэрэг нэвтрээгүй зэргээс шалтгаалан автомашины найдварт ажиллагаа алдагдсан бүрэн бус тээврийн хэрэгсэл замын хөдөлгөөнд оролцох явдал их байна хэмээн дүгнэсэн байна.

“Тээврийн хэрэгслээс ялгарч байгаа хорт бодисын хэмжээг бууруулах арга замууд” (2006 он)

Судалгаагаар Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд оролцож байгаа нийт тээврийн хэрэгслийн 48% нь 10 ба түүнээс дээш жилийн насжилттай байгаа тул импортын тээврийн хэрэгслийн насжилтыг бууруулах, татварын бодлогоор зохицуулалт хийх шаардлагатай гэж үзсэн байна. Мөн 1995 оноос хойш үйлдвэрлэгдсэн автомашины хөдөлгүүрээс гарч байгаа утааг шүүх саармагжуулах катализаторыг техникийн үйлчилгээгээр сольдог байх,

1950 оноос өмнө үйлдвэрлэгдсэн автомашинуудад хөдөлгүүрийн шаталтыг сайжруулах, утааг цэвэршүүлэх төхөөрөмжүүдийг тавих хэрэгтэй гэж үзсэн байна. Манай улсад хэрэглэгдэж байгаа шатахууны чанар автомашинаас гарч буй утаанд тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа тул шатахууны чанарт хяналт тавих систем бий болгох, өндөрт шаталтын зэрэгтэй, хүнд металл агуулаагүй шатахуун импортлох шаардлагатай гэсэн байна.

“Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхыг бэхжүүлэх” төсөл 1-р үе шат (2010-2013 он)

“Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд Жайкагаас 2011 онд хийсэн судалгаагаар автозам дахь хяналтаар СО-гийн хэмжээ 22,919 тонн/жил Noх-ийн хэмжээ 3950 тонн/жил, Sox-ийн хэмжээ 4474 тонн/жил хорт бодис ялгарч байгаа тогтоосон байна. Энэ нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэд дахин их байна. Гэр хорооллын утаа агаарын бохирдлын дийлэнх болдог ч автотээврийн хэрэгслээс ялгарах утаан дахь хорт бодис нь хүний амьсгалах

түвшинд цацагддаг бөгөөд амьсгалын замын цочмог болон архаг өвчин, харшлын эмгэг үүсгэх, элэг, бөөр уушгийг гэмтээх, зүрх судас, мэдрэл сэтгэхүйн эрхтнүүдийн үйл ажиллагааг алдагдуулах, хорт хавдар үүгэх, хүүхдийн өсөлтийг зогсоох үйлчилгээтэй СО, нүүрс устөрөгч НС, хүхрийн давхар исэл SO₂, азотын ислүүд Noх, тоос тоосонцор, тортогжилт РМ зэрэг 200 гаруй төрлийн хорт бодисыг жилийн турш ялгаруулж байдаг.

“Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхыг бэхжүүлэх төсөл” 2-р үе шат (2013-2017 он)

Нийслэлийн агаарын чанарын алба нь ЖАЙКА-гийн төслийн багтай хамтран 2014 оны 8 сараас 2017 оны 1 сар хүртэл АСХУХ-ийг ашиглан Улаанбаатар хотын замын хөдөлгөөнд оролцож буй 20 автомашины зорчих үеийн агаар бохирдуулах бодисын ялгарлын хэмжээг тодорхойлох хэмжилт хийсэн байна. Хаягдал утааны хэмжилтийн дүн нь зорчих хурдаас хамааран өөрчлөгддөг. Иймд уг төслөөр хийсэн хэмжилтийн хурдыг Улаанбаатар хотын зорчих дундаж хурд буюу ойролцоогоор 12.5 км/ц-аар харьцуулалт байна. Хэмжилт хийсэн автомашинуудаас ялгарах NOх болон РМ-ын хэмжээг Японы сүүлийн үеийн ялгарлын стандарт (Евро-5, Евро-6-той адил)-тай харьцуулахад ялгарлын хэмжээ автомашины үйлдвэрлэгдсэн оноос шалтгаалаад харьцангуй үзүүлэлттэй гарсан байна. NOх –ын хэмжээ суудлын автомашины хувьд 10-180 дахин их, том оврын автобусны хувьд 5-10 дахин их, тоосонцор/РМ/-ын хувьд 110-260 дахин их ялгаралтай

буюу харьцангуй өндөр байгааг олж тогтоосон.

Мөн дээрх судалгаагаар УБ хотын суурин харуулын РМ10-ын хэмжилт, 1 цагийн дундаж утга нь 1000 мкг/м³-ээс давсан ноцтой үзүүлэлт хэмжигдсэн байна. РМ10-ын агууламж ихэсгэх хэд хэдэн шалтгаантай бөгөөд автомашины эх үүсвэрийн хувьд дизель хөдөлгүүртэй автомашины хаягдал утааны яндангаас ялгарч буй (РМ) тортогжилт нэгэн шалтгаан юм.

Япон болон Европын орнуудад хэрэгжүүлсэн автомашины хаягдал утааны арга хэмжээнд хүхэр багатай шатахууны нийлүүлэлт маш чухал бөгөөд Монгол улсын хувьд хүхэр багатай шатахууны найдвартай хангамжтай болох хүртэлх хугацаанд дизель хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн тортогжилт РМ-ыг бууруулах оновчтой арга хэмжээ нь хүхэр ихтэй шатахуунд ашиглагддаг DPF шүүлтүүрийг ашиглах хэрэгтэй гэж үзэж байна.

1. Агаарын бохирдол гэж юу вэ?

Агаар нь олон төрлийн хийн хольц бөгөөд азот, хүчилтөрөгч, аргон гэх үндсэн гурван элемент нь агаарын найрлага дахь 99.9 хувийг бүрдүүлдэг. Агаар дахь олон төрлийн хийн найрлага байгалийн болон хүний үйл ажиллагаанаас хамаарч өөрчлөгдөх үед агаарын бохирдол үүсдэг.

Агаарын бохирдлоос үүдэлтэй агаарын дээд давхаргад озоны

хомсдол бий болж, түүний уршгаар хүн төрөлхтний эрүүл мэнд, байгаль орчинд аюул нүүрлэсээр байна. Агаарыг бохирдуулагч олон төрлийн хий, хатуу хольцууд хүний үйл ажиллагаанаас гадна байгалийн замаар үүсдэг. Эдгээр замаар агаарт шууд ялгарах бохирдуулагчийг анхдагч бохирдуулагч гэнэ. Анхдагч бохирдуулагчид хоорондоо болон бусад хийтэй урвалд орсноор шинэ бодис үүсгэх ба үүнийг хоёрдогч бохирдуулагч гэнэ.

| | Хий | Эзлэх хувь |
|----------------------------|-----------------|------------|
| Азот | N ₂ | 78.084% |
| Хүчилтөрөгч | O ₂ | 20.946% |
| Аргон | Ar | 0.934% |
| Нүүрстөрөгчийн давхар исэл | CO ₂ | 0.041332% |
| Неон | Ne | 0.001818% |
| Гелий | He | 0.000524% |
| Метан | CH ₄ | 0.000187% |
| Криптон | Kr | 0.000114% |

Зураг 1. Агаарын бохирдлын төрөл



Гадаад орчны агаарын бохирдол

- Гэр хорооллын айл өрхүүд
- Дулааны цахилгаан станц
- Нам даралтын халаалтын зуух
- Тээврийн хэрэгсэл
- Хог хаягдал
- Ой хээрийн түймэр
- Үйлдвэрлэл, баригдаж буй барилга байгууламж



Дотоод орчны агаарын бохирдол

- Гадаад орчны агаарын бохирдол
- Гал түлэх
- Тамхидалт
- Агааржуулалт

Эх сурвалж: https://en.wikipedia.org/wiki/Atmosphere_of_Earth

1.1 Агаар бохирдуулах бодис



Аливаа эх үүсвэр, эсхүл түүнээс хаягдаж хүрээлэн байгаа агаар бохирдуулж байгаа физик, хими, биологийн болон цацраг идэвхт бодис, тэдгээрийн хольцыг агаар бохирдуулах бодис гэнэ.



Хүснэгт 3. Агаар бохирдуулах бодисын шинж чанар

| | |
|------------------------------------|--|
| Нийт тоосонцор SPM | Агаарт дэгдэх төлөвт тоос шороо, утаа униар, усны уур тодорхой хугацааны туршид оршин байх бөгөөд эдгээр эгэл хэсгүүд алсын барааг муутгадаг. |
| Тоосонцор PM _{2.5} | Агаарт хатуу, шингэн төлөв байдал оршдог. 2.5 микрометрээс бага диаметртэй тоосонцор юм. Агаар дахь нарийн ширхэгт тоос, шингэний жижиг дуслуудаас бүрдэнэ. Байгалийн болон хүний үйл ажиллагааны явцад болон өөр бусад хийн бохирдуулагчид агаарт хоорондоо нэгдэн хувирч тоосонцрыг үүсгэнэ. |
| Тоосонцор PM 10 | 10 микрометрээс бага диаметртэй тоосонцрыг хэлнэ. Энэ тоосонцор агаарт урт хугацааны туршид дэгдэмхий байдлаар орших чадвартай. |
| Хүхэрлэг хий SO ₂ | Өнгөгүй, хурц үнэр, амттай, урвалд идэвхтэй ордог хий. Нүүрс, газрын тосны шаталтаас үүсдэг. Голдуу нүүрс хэрэглэдэг дулааны станцуудаас хаягдана. Мөн цаас боловсруулах болон төмөр хайлуулах үйлдвэрүүдийн үйлдвэрлэлийн процессийн үед ялгардаг байна. |
| Нүүрстөрөгчийн дутуу исэл CO | Өнгөгүй, үнэргүй энэ нь хий бензин, дизель болон нүүрстөрөгч агуулсан түлшний дутуу шаталтаас үүсдэг. Түүнчлэн байгалийн болон байгалийн бус (тамхи мэтийн) бүтээгдэхүүний шаталтаас үүсдэг. |
| Азотын исэл NO _x | Өндөр температурт түлш шатах үед; автотээврийн хэрэгслийн дотоод шаталт, цахилгаан халаагуур, цахилгаан станц, химийн үйлдвэр, хог шатаах зуух зэрэг бохирдуулагч эх үүсвэрээс ялгардаг. |
| Озон O ₃ | Озон нь агаар мандлын дээд эсвэл газрын гадарга орчмын агаарт оршдог. Атмосферийн дээд давхаргад оршин буй озон нь нарны хэт ягаан туяаны хортой нөлөөнөөс хүн, амьтныг хамгаалах биологийн ач холбогдолтой. Харин агаар мандлын доод давхаргад оршин буй озон нь автомашин, цахилгаан станц, уурын зуух, яндангийн утаанаас ялгарсан бохирдуулах бодистой урвалд орж хоёрдогч бохирдуулах бодис болох хүний эрүүл мэндэд хортой озоныг үүсгэдэг байна. |
| Хүлэмжийн хий | Хүлэмжийн хий нь нарнаас ирж буй цацраг туяаг өөртөө шингээж аван цацруулдаг нэгэн төрлийн агаарын давхарга юм. Озон буюу O ₃ , усны уур, метан, нитро буюу N ₂ O, CO ₂ гэсэн хийнүүд нь дэлхийн агаар мандалд зонхилох хүлэмжийн хийнүүд юм. Үүрэг нь дэлхийн эрчим хүчийг зохицуулж, тэнцвэртэй байлгах ба хүлэмжийн хий нимгэрвэл дэлхийд хүйтэн ноёрхох ба эсрэгээрээ нэмэгдвэл дэлхийн дулаарлыг бий болгох аюултай. |

1.2 Агаарын чанарын стандарт MNS 4585:2016

Агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулах бодисын хүлцэх агууламж болон физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг стандартаар тогтоож өгсөн байдаг.

Зураг 2. Хүлцэх агууламжийн ЗДХ мкг/м³

| 24 цагийн дундаж мкг/м ³ | Жилийн дундаж мкг/м ³ | Агаарын чанарын индекс |
|--|-------------------------------------|----------------------------|
| SO ₂ 50 | SO ₂ 20 | 0-50 Цэвэр |
| CO 10000 | - | 51-100 Хэвийн |
| NO ₂ 50 | NO ₂ 40 | 101-200 Бага бохирдолтой |
| O ₃ 100 | - | 201-300 Бохирдолтой |
| PM ₁₀ 100 | PM ₁₀ 50 | 301-400 Их бохирдолтой |
| PM _{2.5} 50 | PM _{2.5} 25 | 401-500 Маш их бохирдолтой |
| Pb 1 | Pb 0.25 | |
| C ₂₀ H ₁₂ 0,001 | - | |

1.3 Агаарын бохирдлын эх үүсвэр

Агаарын бохирдлын эх үүсвэрүүдийг цэгэн, талбайн, шугаман эх үүсвэр болон бусад гэж ангилдаг.¹

Зураг 3. Агаарын бохирдлын эх үүсвэрийн ангилал



Тайлбар

- Хөдөлгөөнт эх үүсвэр - Автомашин, автобус, онгоц, галт тэрэг гэх мэт.
- Суурин эх үүсвэр- Цахилгаан станц, газрын тос боловсруулах үйлдвэр, аж үйлдвэрийн байгууламжууд
- Бүс нутгийн эх үүсвэр- Хот суурин газрын айл өрхүүд, шатаах зуух, газар тариалан, хөдөө аж ахуй
- Байгалийн эх үүсвэр - Салхи шороон шуурга, түймэр, галт уул, элс хайрганы орд гэх мэт

¹ Нийслэлийн агаарын чанарын алба "Нийслэлийн агаарын чанарын төлөв байдал, агаарын бохирдлыг бууруулах талаар хийж гүйцэтгэсэн ажил" 2013 он

Зураг 4. Агаарын бохирдлын эх үүсвэрүүд



Зураг 5. Агаарын бохирдлын хөдөлгөөн



2. Улаанбаатар хотын агаарын бохирдлын өнөөгийн байдал

Хотын агаарын бохирдлыг гэр хороолол, уурын зуух, цахилгаан станц, автомашин болон бусад үүсвэрээс гарч буй бохирдуулагч бодисууд үүсгэж байгаа ч ихээхэн нөлөөлж буй хүчин зүйл бол байгаль, цаг уурын нөхцөл юм.

Монголын нутагт өвөлдөө Сибирийн их даралтын орон (антициклон)-ы нөлөөгөөр үүлгүй, салхи багатай байдаг. Монгол орны төв хэсэг Улаанбаатар хот нь жилийн 4 улирлын муж, онцлогт багтах бөгөөд хүйтний улирал харьцангуй урт үргэлжилдэг.

Өвлийн улирлын дундаж температур -16.7°C - 25.2°C , зуны улирлын дундаж 15.5°C - 18.3°C -ийн хооронд хэлбэлздэг бол жилийн дундаж температур -3.1°C - 1.5°C хоногийн үнэмлэхүй их температур VII сард $+38^{\circ}\text{C}$ - $+39.5^{\circ}\text{C}$ хүрч халдаг бол үнэмлэхүй бага температур I сард -40°C -ээс -46.7°C хүрч хүйтэрдэг.

Зураг 6. Улаанбаатар хот агаарын бохирдол



Зураг 7. Улаанбаатар хотын улирлын горим

50-57 хоног

130-136 хоног



101-108 хоног

63-70 хоног

Хүснэгт 4. Улаанбаатар хотын агаарын дундаж болон үнэмлэхүй бага температур $^{\circ}\text{C}$ /2017-2019 он/

| Сар өдөр | I сар | II сар | III сар | IV сар | V сар | VI сар | VII сар | VIII сар | IX сар | X сар | XI сар | XII сар |
|----------------------------------|-------|--------|---------|--------|-------|--------|---------|----------|--------|-------|--------|---------|
| Агаарын дундаж температур | | | | | | | | | | | | |
| 2017 он | -20 | -13.7 | -4.2 | 5 | 12.7 | 19.3 | 21 | 15.8 | 9.7 | 0.7 | -12.2 | -16.7 |
| 2018 он | -22.4 | -17.7 | -2 | 4.5 | 13.5 | 17.9 | 17.8 | 17.5 | 8.3 | 2.8 | -8.8 | -20.3 |
| 2019 он | -17.9 | -16.7 | -3.8 | 4 | 9.3 | - | - | - | - | - | - | - |
| Үнэмлэхүй бага температур | | | | | | | | | | | | |
| 2017 он | -31.4 | -25.6 | -15.9 | -8.2 | -6 | 4 | 9 | 3.4 | -6.1 | 10.8 | -26.7 | -25.5 |
| 2018 он | -33.8 | -28.3 | -22.1 | -14.1 | -3.7 | 4.4 | 2.7 | 8.4 | -2.6 | 10.6 | -22.3 | -31.1 |
| 2019 он | -29.6 | -32.7 | -14.7 | -10.7 | -6 | | | | | | | |

Эх сурвалж: Цаг уур орчны шинжилгээний газар

Улаанбаатар хотын уур амьсгалд хот орчмын газрын хотгор, гүдгэр (рельеф) онцгой нөлөөтэй бөгөөд эргэн тойрон уул нуруугаар хүрээлэгдсэн тул хүйтний улиралд хүйтэн агаарын "нуур" тогтох газар орчмын агаарын үе давхаргад температурын хүчтэй инверс тогтох боломж ихтэй.

2.1 Улаанбаатар хотын агаарын чанарын төлөв байдал

Улаанбаатар хотын агаарын чанарын хяналт шинжилгээг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), $\text{PM}_{2.5}$, PM_{10} тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O_3) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар болон химийн аргаар тодорхойлж байна.


Улаанбаатар хотын агаарын чанарын хяналт шинжилгээний сүүлийн 3 жилийн дүнгээс үзэхэд өвлийн саруудад агаар дахь түгээмэл тархацтай бохирдуулагч бодисын дундаж агууламж стандарт хэмжээнээс 1-4 дахин их үзүүлэлттэй буюу маш их бохирдолтой, хавар, намрын улиралд 1.1-1.5 дахин их, зуны улиралд стандартаас давсан тохиолдол байхгүй хэвийн үзүүлэлттэй байна.

Өвлийн улиралд агаарын үнэмлэхүй бага температур арван хоёр, нэг, хоёрдугаар сард тохиох бөгөөд эдгээр өдрүүдэд агаарт агуулагдах бохирдуулагч бодисын дундаж хэмжээ дээд төвшинд хүрдэг байна.

Хүхэрлэг хий SO_2

Агаарт агуулагдах SO_2 -ын хэмжээ АЧС-аас 2017 оны нэгдүгээр сард $32\text{мкг}/\text{м}^3$ буюу 64%-иар, 2018 оны арван хоёрдугаар сард $6\text{мкг}/\text{м}^3$ буюу 12%-иар, 2019 оны нэгдүгээр сард $11\text{мкг}/\text{м}^3$ буюу 22%-иар тус тус их байсан бөгөөд үлдсэн саруудад хэвийн үзүүлэлттэй байна.

График 1. Хүхэрлэг хийн дундаж хэмжээ 2017-2019




Азотын давхар исэл NO_2

Агаарт агуулагдах NO_2 -ын хэмжээ 2017 оны арван хоёрдугаар сард стандарт хэмжээнээс $12\text{мкг}/\text{м}^3$ буюу 24%-иар, нэгдүгээр сард $23\text{мкг}/\text{м}^3$ буюу 46%-иар их, хоёрдугаар сард $4\text{мкг}/\text{м}^3$ 8%-иар их байсан бол 2018 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартаас давсан үзүүлэлт байхгүй хэвийн, 2019 оны нэгдүгээр сард агаарт агуулагдах NO_2 -ын хэмжээ стандартаас давсан буюу 18%-иар их байсан.

Өвлийн улирлын арван хоёр, нэг, хоёрдугаар саруудад агаарт агуулагдах NO_2 -ын хэмжээ зуны саруудаас 2-3 дахин их байдаг байна.

График 2. Азотын давхар ислийн хэмжээ 2017-2019 он




Нарийн ширхэглэгт тоосонцор PM10

Агаарт агуулагдах тоосонцорын хэмжээ цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалж жилийн турш тогтмол стандартаас давсан үзүүлэлттэй байгаа ба зуны улирлын зургаа, долоо, наймдугаар сар, намрын улирлын есдүгээр саруудад жилийн нийлбэр хур тунадасны 79.5%² ордог бөгөөд агаарын чийгшил харьцангуй нэмэгдэн нарийн ширхэглэгт тоосонцорын хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.

Агаарт агуулагдах PM10-ын сүүлийн 3 жилийн дүнгээс үзэхэд өвлийн улирлын арван хоёр, нэгдүгээр саруудад АЧС-аас 109-140 мкг/м³-аар буюу 2.09-2.4 дахин их, хоёрдугаар сард 55-92 мкг/м³-аар буюу 1.5-1.9 дахин их, гурав дөрөвдүгээр саруудад агаарын хэм харьцангуй нэмэгдэх хэдий ч салхи, шороон шуурганы улмаас PM10-ын хэмжээ стандартаас мөн давсан үзүүлэлттэй 15-48 мкг/м³ буюу 1.1-1.48 дахин их байна.

График 3. Нарийн ширхэглэгт тоосонцорын хэмжээ PM10 /2017-2019 он/




² Монгол орны хэмжээнд 6 дугаар сард ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 18%, 7 дугаар сард 28.5 %, 8 дугаар сард 24.3% 9 дүгээр сард 8.7% нь ордог. / Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн/

Нарийн ширхэглэгт тоосонцор PM2.5

Агаарт агуулагдах PM2.5-ын хэмжээг сүүлийн 3 жилийн дүнгээс үзэхэд өвлийн улирлын арван хоёр, нэгдүгээр саруудад АЧС-аас 126-151мкг/м³ буюу 2.5-3 дахин их байсан байна.

2017 оны хоёрдугаар сард агаарт агуулагдах PM2.5-ын хэмжээ 74мкг/м³ буюу 1.48 дахин их, 2018 оны хоёрдугаар сард 76 мкг/м³ буюу 1.52 дахин их байсан бол 2019 оны мөн үед 62 мкг/м³ буюу 1.24 дахин их буюу өмнөх оноос 12%-иар буурсан үзүүлэлттэй байна. Хавар, зуны улиралд тоосонцорын хэмжээ хэвийн үзүүлэлттэй намрын улирал аравдугаар сард АЧС-аас бага зэрэг давсан, арван нэгдүгээр сард 1.06-1.56 дахин их үзүүлэлттэй байна.


График 4. Нарийн ширхэглэгт тоосонцрын хэмжээ PM2.5 /2017-2019/



Хүлэмжийн хий

Хүлэмжийн хий нь нарнаас ирж буй цацраг туяаг өөртөө шингээж аван цацруулдаг нэгэн төрлийн агаарын давхарга юм. Озон буюу O³, усны уур, метан, нитро буюу N²O, CO² гэсэн хийнүүд нь дэлхийн агаар мандалд зонхилох хүлэмжийн хийнүүд юм. Үүрэг нь дэлхийн эрчим хүчийг зохицуулж, тэнцвэртэй байлгахад оршдог. Хэрэв хүлэмжийн хий нимгэрвэл дэлхийд хүйтэн ноёрхох ба эсрэгээрээ нэмэгдвэл дэлхийн дулаарлыг бий болгох аюултай.

График 5. Хүлэмжийн хийн хэмжээ /2017-2019/



2.2 Улаанбаатар хотын агаарын чанарын индекс

2018.01.01-2018.12.31-ны хооронд хийгдсэн нийслэлийн агаарын чанарын хяналт шинжилгээний дүнгээр гэр хороолол орчимд жилд дунджаар 155 хоногт АЧИ цэвэр болон хэвийн үзүүлэлттэй, бага бохирдолтой хоногийн тоо дунджаар 141, бохирдолтой хоногийн тоо дунджаар 35, их бохирдолтой хоногийн тоо 21, маш их бохирдолтой хоногийн тоо дунджаар 13 байна.

Орон сууц хороолол орчимд жилийн дийлэнх хувьд нь буюу дунджаар 271 хоногт агаарын чанарын индекс 101-200 хооронд бохирдолтой гэсэн үзүүлэлттэй байна. Автозам орчимд АЧИ үзүүлэлт жилд дунджаар 21 хоног цэвэр, 60 хоног хэвийн, 236 хоног буюу дийлэнх хувьд нь бага хэмжээний бохирдолтой байсан ба бохирдолтой хоногийн тоо 25, их бохирдолтой хоногийн тоо 19, маш их бохирдолтой хоногийн тоо 6 байна.

Үйлдвэрийн болон алслагдмал бүсэд агаарын чанар харьцангуй цэвэр, хэвийн үзүүлэлттэй байна. Жилд дунджаар 99 хоног цэвэр, 113 хоног хэвийн, 131 хоног бага хэмжээний бохирдолтой, үлдсэн 24 хоног АЧИ 201-с дээш буюу бохирдолтой, их хэмжээний бохирдолтой гэсэн үзүүлэлттэй гарсан байна.


Хүснэгт 5. Улаанбаатар хотын агаарын чанарын индекс /2018 он 365 хоног/

| АЧИ хоногоор | Гэр хороолол орчим | | | | | Орон/с хороолол | Автозам орчим | | Үйлдвэрийн болон алслагдмал бүс | |
|-------------------------------|--------------------|---------|-------|--------|-----------|--------------------|------------------|---------|---------------------------------------|-------------|
| | 100 айл | Толгойт | Нисэх | Зурагт | Баянхошуу | 13-р хороолол | Баруун 4 зам | Амгалан | Цахилгаан станц | Ургах наран |
| Цэвэр | 39 | 51 | 78 | 51 | 62 | - | 4 | 37 | 74 | 123 |
| Хэвийн | 100 | 155 | 70 | 104 | 64 | 57 | 15 | 104 | 91 | 134 |
| Бага бохирдолтой | 173 | 105 | 164 | 127 | 137 | 271 | 292 | 180 | 161 | 101 |
| Бохирдолтой | 25 | 31 | 22 | 38 | 59 | 13 | 34 | 15 | 16 | 5 |
| Их бохирдолтой | 20 | 15 | 20 | 35 | 17 | 23 | 14 | 23 | 18 | 1 |
| Маш их бохирдолтой | 8 | 8 | 11 | 10 | 26 | 1 | 6 | 6 | 5 | 1 |

Эх сурвалж: Агаарын чанарын хяналт шинжилгээ <http://www.agaar.mn>

Улаанбаатар хотын хувьд жилийн турш нарийн ширхэглэгт тоосонцор PM10, PM2.5-ын хэмжээ тогтмол их байдаг ба хүйтний улиралд буюу X-V сарын хооронд харьцангуй өндөр үзүүлэлттэй байна. Орон сууц хороолол орчимд жилийн турш агаарын чанар тогтмол бохирдолтой гэсэн үзүүлэлттэй байгаа ба хүйтний улиралд агаарт агуулагдах NO2, PM2.5, PM10 нэмэгддэг. Автозам орчим агаарт агуулагдах NO2-ын хэмжээ бусад цэгүүдтэй харьцуулахад тогтмол их байгаа бол хүйтний улиралд алслагдмал бүсийн хувьд PM10-ын хэмжээ нэмэгддэг.

График 6. Автозам орчмын АЧИ улирлаар (2018 он)



Дэлхийн дээр агаарын чанарын индексийг хэмжигч, тоосонцор болон бохирдлыг лазераар мэдрэгч өндөр нарийвчлал бүхий 10,000 гаруй төхөөрөмж ажиллаж байгаа бөгөөд эрчим хүч интернетиин тусламжтайгаар агаарын бохирдлын төвшинг тогтмол мэдээллэдэг байна. Улаанбаатар хот 2018 оны байдлаар агаарт агуулагдах нарийн ширхэглэгт тоосонцор PM_{2.5}-н бохирдлын зэргээр дэлхийд 5 дугаарт бичигдэж байна.


График 7. Улс хотуудын PM_{2.5}-ын дундаж хэмжээ /2018 он/



2.3 Агаарын бохирдол-Эрүүл мэнд

Хүний эрхтэн тогтолцооны өөрчлөлтөд агаар мандалд буй олон төрлийн бодисууд дангаараа болон хамтран нөлөөлдөг. Тэдгээрээс бүх тогтолцоонд сөрөг нөлөөтэй нь PM2.5 болон PM10 тоосонцор юм. PM2.5 тоосонцрын агууламж хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү гарснаар амьсгалын тогтолцооны, хавдар, зүрх судасны тогтолцооны болон нөхөн үржихүйн тогтолцооны өвчлөлийн шалтгааны нэг болдог байна.

Зураг 8. Агаарын бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх хор, нөлөө



Эх сурвалж: Улаанбаатар хотын гадаад орчны агаарын бохирдол ба эрүүл мэнд судалгаа -2019 он.

Агаарын бохирдол хүний эрүүл мэндэд нөлөөлөх үзүүлэлтийг физиологи, дархлал, өвчлөл гэсэн 3 бүлэгт хувааж үздэг. Үүнд:

| ФИЗИОЛОГИ | ДАРХЛАЛ | ӨВЧЛӨЛ |
|---|--|---|
| <ul style="list-style-type: none"> Уушгины үйл ажиллагаа буурах Оюуны ажиллах чадамж буурах Мэдрэхүй-хөдөлгөөний хурд удаашрах Цусны даралт, судасны цохилтын тоо өөрчлөгдөх Хүүхдийн бие махбодын өсөлт, хөгжилтөд сөрөг нөлөөлөх | <ul style="list-style-type: none"> Хэсэг газрын дархлаа сулрах Биеийн ерөнхий эсэргүүцэл сулрах сөрөг нөлөөлөх | <ul style="list-style-type: none"> Амьсгалын тогтолцоо Харшил Зүрх судас Нүд, чих хамар хоолой Төрөлхийн гаж хөгжил Нөхөн үржихүйн Хавдар (уушгины) Бусад өсөлт, хөгжилтөд сөрөг нөлөөлөх |

Агаарын бохирдол эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох статистикийг Үндэсний статистикийн хорооноос 2019 онд хийсэн "Улаанбаатар хотын гадаад орчны агаарын бохирдол ба эрүүл мэнд" судалгаанаас үзнэ үү. Тус судалгааны ажилтай дараах холбоосоор хандаж танилцах боломжтой.

https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=UB_health_airpolution_2019.pdf&ln=Mn

4. “Авто машины нүүрсэн яндангийн зориулалт, ач холбогдол”.

Автомашинь хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагч бодисууд нь хүний эрүүл мэндэд хор хөнөөл учруулж, уур амьсгалын өөрчлөлтийг үүсгэдэг хүлэмжийн хийг нэмэгдүүлдэг. Бензин, дизель түлшийг шатаахад азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл, нүүрс устөрөгч, бензол, формальдегид зэрэг хортой 200 гаруй бодисууд (түлшний чанар болон бусад холбогдох хүчин зүйлсийн нөлөөллөөр 300 хүртэлх төрлийн хорт бодис ялгардаг) бий болохоос гадна хамгийн түгээмэл хүлэмжийн хий болох нүүрстөрөгчийн давхар ислийг ихээр үүсгэдэг.

Америкийн нэгдсэн улсын Environmental Protection Agency байгууллагын хийсэн судалгаагаар хот суурин орчмын агаар мандал дахь бүх нүүрстөрөгчийн дутуу ислийн (CO) 95% нь автомашинаас ялгарч, жил бүр 1.7 тэрбум тонн хүлэмжийн хий үүсгэдэг болохыг тогтоосон байна.

Автомашинь ялгарах хорт бодисын хэмжээ ба түүнээс үүдэх агаарын бохирдлыг бууруулахын тулд олон улсад TA 9/2009, FR 9/2011, UN Reg 83, 70/220EC, 715/2007EC, 2017/1151, 692/2008EC, EURO-5 зохицуулалтууд болон холбогдох бусад бүх нийтээр дагаж мөрдөх баримт бичгээр автомашинаас ялгарах утаан дахь хорт бодисын хэмжээг бууруулах, саармагжуулах төхөөрөмжид тавигдах техникийн шаардлага болон утаанд агуулагдах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоож, дагаж мөрдөх үүргийг үйлдвэрлэгчдэд хүлээлгэсэн байдаг.

Тухайлбал Евро 5 стандарт 2009 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж, тус стандартаар хөдөлгүүрээс ялгарах утаан дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг CO – 1 g/km, HC/NOx-0.1 g/km, PM – 0.005 g/km байхаар тогтоож тухайн шаардлагыг хангах тээврийн хэрэгсэл нь дор хаяж дараах төхөөрөмжөөр тоноглогдсон байх шаардлагыг тавьсан.

Тус шаардлагын дагуу үйлдвэрлэгчид хорт бодисын хэмжээг зөвшөөрөгдөх дээд хэмжээнд хүртэл саармагжуулах боломжтой дараах систем, төхөөрөмжөөр автомашиныг бүрэн тоноглож эрх бүхий олон улсын хяналтын байгууллагаар сорилт, туршилт хийлгэн баталгаажуулж зах зээлд нийлүүлдэг. Үүнд:

- EGR хяналтын систем
- EGR урсгал ба хөргөлт хяналтын систем
- DPF ба Тоосонцрын шүүлтүүр
- Түлш цацалтын систем
- Катализатор буюу саармагжуулагч (NMHC 3)
- NOx катализатор (> Euro 5+) 3) 4)
- NOx -ийг урвалд оруулсны дараа дахин хянах систем
- Бүх O2 мэдрүүр (in addition to front sensor)
- PM хяналтын систем
- IUPR (> Euro 5+)


Эх сурвалж: 70/220EC, 715/2007EC болон EURO 5 зохицуулалт

Эдгээр төхөөрөмжүүд нь автомашины хөдөлгүүрээс ялгарах утаанд агуулагдах хорт бодисын хэмжээг 90-99%-иар бууруулдаг.

Жишээлбэл бензин хөдөлгүүртэй автомашинд суурилуулсан катализатор нь хөдөлгүүрээс ялгарах нүүрс устөрөгч (HC), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) болон азотын ислийг (NO_x) 95% -иар бууруулж байгаан The International Platinum Group Metals Association (IPA) байгууллагын хийсэн сорилт, туршилтаар батлагдсан байна.

Бензин хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэлд заавал суурилуулсан байх ёстой төхөөрөмжийн жагсаалтад орсон катализатор/нүүрсэн яндан нь утааны ялгарал хяналтын системийн хамгийн чухал хэсэг бөгөөд хөдөлгүүрээс ялгарах утаанд агуулагдах азотын исэл (NO_x), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), нүүрсустөрөгч (HC) зэрэг хортой бохирдуулагчийг химийн урвалд оруулж нүүрстөрөгчийн давхар исэл (CO₂), азот (N₂), ус (H₂O) зэрэг сөрөг нөлөөлөлгүй хаягдал болгон хувирган гаргах зориулалттай ба бүтэц нь дараах эд анги, материалаас бүрддэг.

- Цагаан алт (Pt), Палладий (Pd), Родий (Rh)
- Оруулах болон гаргах хоолой
- Ган гэр/их бие
- Дулаан тусгаарлагч
- Хүчил төрөгчийн мэдрүүр суух үүр
- Церий ба керамик зөгийн үүрэн бүтэцтэй урвалд оруулагч элемент
- Урвалд оруулагч идэвхит материал/хөнгөн цагаан-AL203, Церийн исэл- CeO₂.
- Угаарын хий, нүүрс устөрөгч саармагжуулагч элемент
- Азот исэл саармагжуулагч элемент



Катализаторын гол эд анги, бүрэлдэхүүн хэсэг нь найрлагандаа байгалийн ховор, үнэтэй метал болох Цагаан алт (Pt), Палладий (Pd), Родий (Rh)-г агуулсан зөгийн үүр хэлбэрийн урвалд оруулагч элемент юм.

Зөгийн үүрэнд агуулагдах цагаан алтны бүлгийн металлууд нь автомашины хөдөлгүүрээс ялгарах утаанд агуулагдах нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), нүүрс устөрөгч (HC) болон азотын ислийг (NO_x) бага хортой нүүрстөрөгчийн давхар исэл (CO₂) болон ус (H₂O) болгон хувиргадаг бол палладийн нүүрс устөрөгчийг усны

уур, нүүрстөрөгчийн давхар исэл болгон задалж, родиум нь азотын исэл ба нүүрстөрөгчийн дутуу ислийг азот, нүүрстөрөгчийн давхар исэл болгон хувиргадаг.

Нэг катализаторт дунджаар 3-7 грамм цагаан алт (Pt), 2-7 грамм палладий (Pd), 1-2 грамм родий (Rh) агуулагддаг. Зарим тохиолдолд автомашины төрөл, загвар, зориулалтаас хамаарч стандарт хэмжээнээс (том хөдөлгүүртэй жийп эсвэл ачааны машин 6-30 орчим грамм) их байдаг.

2022 оны 04 сарын 05-ны өдрийн байдлаарх дээрх үнэт металлын 1 грамм тутамд ногдох үнийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 6. Катализаторт агуулагдах үнэт металл ба үнэ

| | 2022 оны 04 сарын 05-ны байдлаар- USD | | |
|---------|---------------------------------------|----------------|------------|
| | Цагаан алт (Pt) | Палладий (Pd), | Родий (Rh) |
| 1 грамм | 32.89\$ | 72.9\$ | 608\$ |

Эх сурвалж: <https://www.moneymetals.com/rhodium-price>

Катализаторт агуулагдах үнэт металлтай ижил хэмжээний үнэт металлыг 360 кг хүдэр байгалаас олборлож, боловсруулж гаргаж авах боломжтой байдаг. Хүдэр олборлох, боловсруулах үйлдвэрийн технологи процесс, зардал зэрэгтэй харьцуулбал 1.5 кг жинтэй катализаторыг дахин боловсруулж түүнээс үнэт металл гаргаж авах ажил нь хамаагүй хялбар, хурдан, зардал багатай арга учраас энэ төрлийн бизнес эрхлэгчид маш олон байдаг. Үүнийг дагаад тэдгээрт ханган нийлүүлэлт хийх зорилгоор автомашинаас салгаж зарах, хулгайлах зэрэг гэмт хэрэг, зөрчлүүд маш ихээр гардаг.

Автомашины хөдөлгүүрээс ялгарах утаанд агуулагддаг онц аюултай нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), нүүрс устөрөгч (HC), азотын исэл (NO_x), хортой бохирдуулагч, утаа үүсгэгч бодисууд, хүхрийн исэл, тоосонцор, хар тугалганы нэгдлүүд, альдегид, бензапирен болон бусад 200 гаруй химийн хорт бодисууд катализаторгүй тохиолдолд шууд агаар мандалд цацагдаж ноцтой аюулд хүргэдэг учраас катализаторыг салгаж авах, зарах, хулгайлах зөрчил нь хүн болон хүрээлэн буй орчны эсрэг хийж буй онц аюултай үйлдэл гэж олон улсад үздэг.

5. “Тус зөрчлийн эсрэг цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал”.

Олон улсын зах зээлд цагаан алт, родий, палладий зэрэг үнэт металлуудын эрэлт ихсэж, үнэ нэмэгдэж байгаатай холбоотойгоор автомашины катализаторыг дахин боловсруулж үнэт метал гарган авч худалдаалах хандлага ихээхэн гарч байна.

Үүнтэй холбоотойгоор автомашины катализаторыг зарах, хулгайлах, дамлах гэмт хэргийн тохиолдол дэлхий дахинд огцом нэмэгдсэн. Жишээлбэл Их Британи улсад 2018 онд 1674, 2019 онд 2484, 2020 онд 14690 катализатор хулгайлагдсан бол 2021 онд хулгайн тохиолдол 4 дахин нэмэгдсэн байна.

Катализаторын хулгайд ихэвчлэн хайбрид буюу хосолсон хөдөлгүүтэй Prius маркийн автомашин их өртдөг. Учир нь энэ төрлийн автомашин хийцийн онцлогоос шалтгаалж (жишээлбэл бензин хөдөлгүүртэй автомашинтай адил хугацаанд катализаторыг халаах) катализаторт дээрх үнэт металлын хэмжээг стандарт хэмжээнээс их хийдэгтэй болон энэ төрлийн автомашины катализатор бага гэмтдэгтэй холбоотой.

Монгол улсад Prius 20 маркийн автомашины катализатор ихээр хулгайлагддаг ба боловсруулж үнэт металлыг гаргаж авахаас илүүтэйгээр Хятад улсад гаргаж зарах, дотооддоо үнэ нэмж дамлаж зарах хэлбэр илүү зонхилдог.

Олон улсад катализаторын хулгайд хамгийн их өртдөг автомашины төрөл:

1. Хайбрид буюу Хосолсон хөдөлгүүртэй,
2. Эхэн үеийн катализатор суурилуулагдсан,
3. SUV ангиллын жийп

Мөн сүүлийн жилүүдэд баталгаат катализаторгүй буюу үйлдвэрлэгчээс суурилуулсан катализаторыг сольсон, эсвэл авсан автомашин Монгол улсад импортлогдох болсон ба Хятадад үйлдвэрлэсэн хуурамч (шинэ) катализаторыг үйлдвэрлэгчийн суурилуулсан катализатороор солих, зөрүү үнийг өгөх зэрэг хууль бус зөрчлүүд ихээхэн гарч байна.

Олон улсад катализаторын хулгайн гэмт хэрэгтэй олон аргаар тэмцэж байгаа бөгөөд эдгээрээс хамгийн нийтлэг авч хэрэгжүүлж буй зарим арга хэмжээг (торгууль, шийтгэлээс бусад) Монгол улсад гарч буй зөрчилтэй уялдуулан дараах саналыг хүргүүлж байна.

1. Гарал үүсэл, болон чанарын баталгаагүй катализатор болон түүнтэй адилтгах төхөөрөмж, эд ангийг Монгол улсын нутаг дэвсгэрт импортлох, худалдаалахыг хориглох.
2. Катализатор болон утаа ялгарлыг хянах төхөөрөмж, системгүй тээврийн хэрэгслийг Монгол улсын хилээр нэвтрүүлэхгүй байх тухай зүйл, заалтыг импорт болон гаалийн холбогдох дүрэм журам болон техникийн зохицуулалтад тусгах,
3. Хулгайд хамгийн их өртөж буй prius маркийн автомашин болон бусад автомашины VIN дугаарыг катализаторын их биедээр бичих, бүртгэлжүүлэх.

4. Катализатор худалдаалдаг, худалдан авдаг, засвар, үйлчилгээ хийдэг хуулийн этгээд, иргэнийг бүртгэлжүүлэх, тэдгээрийн бараа бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох, бүртгэх, хянах.

УУЛСЫН ГИШҮҮН



УИХЫН ГИШҮҮН

САНДАГИЙН БЯМБАЦОГТ

- Боловсруулж буй
- Өргөн баригдсан
- Хэлэлцэх эсэх
- Ажлын хэсэг
- Анхны хэлэлцүүлэг
- Эцсийн хэлэлцүүлэг
- Батлах

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 ОНЫ 5 Р САРЫН 6 ӨДӨР

УЛАМНБМТАР

ТОГТООЛД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ



Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3 дахь хэсгийн “зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа хар болон өнгөт төмөрлөгөөр хийсэн сэлбэг, бүтээгдэхүүн” гэсний дараа “автомашины нүүрсэн яндан, нүүрсэн яндангийн хаягдал” гэж нэмсүгэй.

2. Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ТӨСЛИЙН ФАЙЛУУД

ӨРГӨН МЭДҮҮЛЭХ - ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

ӨРГӨН МЭДҮҮЛЭХ - ТАНИЛЦУУЛГА

ӨРГӨН МЭДҮҮЛЭХ - ЗАРДЛЫН ТООЦООНЫ СУДАЛГАА

Үзэл баримтлал
(Үзэл баримтлал (2).docx)

